



БОЛОВСРОЛЫН
ЯАМ

БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ 2024-2025



БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ 2024-2025

УЛААНБААТАР ХОТ
2025 он

Боловсролын яам 2025 онд хэвлэв.

© БЯ

Боловсруулсан:

Боловсролын яам, Боловсролын статистик мэдээллийн хэлтэс

Д.Анхзаяа, БЯ-ны Боловсролын статистик мэдээллийн хэлтсийн ахлах шинжээч

Ц.Батбаяр, БЯ-ны Боловсролын статистик мэдээллийн хэлтсийн шинжээч

Уг эмхэтгэлийн өгөгдлийг дижитал хэлбэрээр болон эксел хүснэгтээр ашиглахыг хүсвэл та дараах QR кодыг ашиглана уу.

Эмхэтгэлийн мэдээллийг ашигласан тохиолдолд "Боловсролын салбарын статистикийн мэдээлэл 2024-2025", Боловсролын яам хэмээн эх сурвалж хэсэгт тодотгоно уу. Санал хүсэлт болон агуулгатай холбоотой лавлах зүйл байвал ankhzaya@moe.gov.mn цахим шууданд ирүүлнэ үү.

Дижитал хувилбар:



Эксел файл татах:





АГУУЛГА

01	БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ	7	02	БОЛОВСРОЛЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ	22
03	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ	30	04	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ	46
05	МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ	87	06	ДЭЭД БОЛОВСРОЛ	109
07	НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛ	126			



МЭНДЧИЛГЭЭ

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн тэргүүлэх чиглэлийн нэг нь “Боловсролын салбарын шинэчлэл” байхаар туссан. Энэхүү онцлог бүхий хичээлийн жилд зориулсан “Боловсролын салбарын статистикийн мэдээлэл 2024-2025” эмхэтгэлийг Та бүхэнд хүргэж байна.

Та бүхэн энэхүү эмхэтгэлээс боловсролын салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний хэрэгжилтийн үр дүнгийн өнөөгийн нөхцөл байдалтай танилцаж, 2028 он хүртэлх төлөвлөлтөө хийхэд туслах суурь мэдээлэлтэй болно хэмээн итгэж байна.

2024-2025 оны хичээлийн жил бол Боловсролын багц хууль хэрэгжиж эхэлсэн хоёрдох жил. Боловсролын ерөнхий хуульд бид боловсролыг хөгжлийн тэргүүлэх салбар гэж үзэн, бодлого, үйл ажиллагаандаа баримтлах зарчмаа шинэчлэн тогтоосон. Үүний нэг болох тэгш хүртээмжтэй, ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг хэрэгжүүлж, боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа хүүхэд, эрх нь хязгаарлагдсан хүний сурч боловсрох эрхийг хангах, үндэстний цөөнх хүүхдийн хос хэлний боловсрол зэрэг чиглэлийн ажлуудыг эхлүүлэв. Тухайлбал, энэ жил бид тэгш хамран сургах боловсролын чиглэлээр 40 гаруй мянган багшийг сургалаа.

Сургуулийн өмнөх боловсролын, ялангуяа 5 настай хүүхдийн хамрагдалт төлөвлөсөн түвшнээс ахиж 94.1 хувьд хүрсэн үр дүнтэй байна. Бид төр, олон нийтийн оролцоог хангасан, хамтын хариуцлагатай байх зарчмыг баримтлан, хүүхдийг шим тэжээлийн тэнцвэртэй хоол хүнсээр хангах, эрүүл зөв хооллолтын дадлыг хэвшүүлэх зорилгоор цэцэрлэгийн хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын тодорхой хэсгийг эцэг эх, асран хамгаалагч нь хариуцах тухай хуулийн заалтыг 2024 оноос хэрэгжүүлж эхэллээ.

Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт нь төлөвлөх, боловсруулах, турших, сайжруулах, хэрэгжүүлэх, үнэлэх үйл явцыг багтаасан тасралтгүй, цогц үйл ажиллагаа байдаг. Иймд үндэсний сургалтын хөтөлбөрүүд залгамж холбоотой, тогтвортой байх нөхцөлийг хангах зорилгоор “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал”-ыг батлуулж, хөтөлбөрийн шинэчлэлийг эхлүүлж чадлаа. Энэ хүрээнд сургуулийн өмнөх болон бага боловсролын хөтөлбөрийг боловсруулж, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн түшиц 18 цэцэрлэг, ерөнхий боловсролын 27 сургуульд тохирцыг шалгаж, цаашлаад үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхэд бэлтгэж байна.

Аливаа салбарын бодлогыг амжилттай хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулалт, санхүүжилт салшгүй холбоотой.

Бодлогодоо тохирсон санхүүжилт байх уу, эсвэл санхүүжилтдээ тохирсон бодлого боловсруулж хэрэгжүүлэх үү? гэсэн асуулт зүй ёсоор урган гардаг. Энэ үүднээс 2024-2025 оны хичээлийн жилд “Хүртээмжээс чанарт” зарчимд суурилсан санхүүжилтийг хэрэгжүүлж байна.

Боловсролын хууль тогтоомжийн шинэчлэл, цахим боловсрол, хүн бүр чанартай боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлэхтэй уялдсан санхүүжилтийн хүрээнд бид ерөнхий боловсрол эзэмшүүлэхэд нэг хүүхдэд ногдох хувьсах зардлыг 1-12 дугаар анги бүрээр тооцон шинэчилж, математик, англи хэл, мэдээлэл технологийн хөтөлбөрүүдийг олон улсын жишигт нийцүүлж сайжруулах, цахим сургалтын орчныг бүрдүүлэх, шаардлагатай дэд бүтэц, үйлчилгээг төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд гүйцэтгэх, мэргэжлийн болон техникийн боловсрол мэргэжлийн өртөгт суурилсан хувьсах зардлыг хэрэгжүүлэх зэрэг ажлыг эхлүүлээ.

Мэргэжлийн болон техникийн боловсролын мэргэжлийн чиглэл, индексийг шинэчлэн батлахдаа Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 227 дугаар тогтоолоор батлагдсан Мэргэшлийн үндэсний шаталсан бүтцэд нийцүүлэн хөдөлмөрийн зэх зээлийн эрэлт, шаардлагад нийцсэн мэргэжилтэй ажилтныг бэлтгэхэд голчлон анхаарав.

Боловсролын цахим мэдээллийн сан бүрдүүлэх, ажиллуулах журмыг баталснаар төр болон систем хөгжүүлэгч хувь хүн, хуулийн этгээд хоорондоо цахим систем ашиглан мэдээлэл солилцдог боллоо.

Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг соёрхон батлуулснаар Монгол Улс Нэгдсэн үндэстний байгууллагаас дэлхийн хэмжээнд дээд боловсролын салбарыг хамруулан гаргасан гэрээнд нэгдсэн 34 дэх улс болов.

Дээрх олон эерэг үр дүн нь бодит байдлыг илэрхийлэх статистик, тоон мэдээллийн дүн шинжилгээ бүхий нотолгоонд суурилсан оновчтой бодлого, шийдвэрийг

хэрэгжүүлсний үр дүн гэж ойлгож байна.

Ялангуяа боловсролын салбарын статистик өгөгдөл мэдээллийг хиймэл оюун ухаан ашиглан боловсруулж, өнөөгийн дүр төрхийг гаргахаас гадна ирээдүйн чиг хандлагыг таамаглах боломжтой дижитал шилжилтийн энэ үед статистик мэдээлэл, өгөгдлийн дүн шинжилгээнд суурилсан ухаалаг шийдвэр гаргалтад анхаарал хандуулах нь чухал байна.

Эмхэтгэлийн нүүр хуудаст байрлах QR кодыг уншуулж цахим хэлбэрээр татан авах, ухаалаг дижитал дашборд дээр ажиллах боломжтой.

Эрхэм уншигч Та бүхэн бодлого, төлөвлөгөө, арга хэмжээ болон судалгаа, шинжилгээндээ манай салбарын статистик мэдээллийн цахим эмхэтгэл, дижитал дашбордыг өргөнөөр ашиглана хэмээн итгэж байна.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН, БОЛОВСРОЛЫН САЙД

ПҮРЭВСҮРЭНГИЙН НАРАНБАЯР



ТАЛАРХАЛ

Боловсролын яамны Боловсролын статистик мэдээллийн хэлтсээс “Боловсролын салбарын статистикийн мэдээлэл 2024-2025” эмхэтгэлийн 4 дэх хэвлэлийг боловсруулан Та бүхэнд хүргэж байна.

Энэхүү эмхэтгэлийг боловсруулахад бодлого, шийдвэр, тэдгээрийн үр дүнгийн мэдээллээ нээлттэйгээр хуваалцан, цаг заваа зарцуулан хамтран ажилласан Та бүхэнд талархал илэрхийлж байна.

- Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал
- Боловсролын нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын дарга П.Оюунаа
- Цахим боловсролын газрын ахлах шинжээч О.Дүнжиннамдаг
- Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын ахлах шинжээч Б.Доржхуяг
- Мэргэжлийн болон техникийн боловсролын газрын шинжээч П.Болормаа

Та бүхэнд ажлын өндөр амжилт хүсэн ерөөе.

БОЛОВСРОЛЫН ЯАМНЫ БОЛОВСРОЛЫН СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН ХЭЛТЭС



01

БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

1.1

ЭРДЭМ БОЛОВСРОЛТОЙ МОНГОЛ ХҮН
БОДЛОГО

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор "Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг баталсан. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн тэргүүлэх чиглэлийн нэг нь "Боловсролын салбарын шинэчлэл" болсон ба үндсэн **4 зорилтын хүрээнд 40 үйл ажиллагаа** хэрэгжүүлэхээр тусгасан.



2025 ОНЫ БОДЛОГЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ



Дижитал шилжилт, технологийн өөрчлөлт, шинэчлэлийн сорилтыг даван туулах чадвартай, монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч хүмүүжлийг олгох боловсролын үндэсний хөтөлбөрийг хөгжүүлнэ.



Хот, суурин газрын сургууль, цэцэрлэгийн бүлэг дүүргэлтийг стандартын түвшинд хүргэх "Нэг ээлж, цөөн хүүхэдтэй анги", "Гэрт ойр сургууль/цэцэрлэг-хамгийн сайн сургууль/цэцэрлэг" арга хэмжээг хэрэгжүүлнэ.



Ерөнхий боловсролын сургуулийн 3 дугаар ангиас эхлэн англи хэл, кодчилал, роботик болон хиймэл оюуны ур чадварыг хөгжүүлэх сургалтыг нэвтрүүлнэ. Бүх түвшинд англи хэлний сургалтын чанарыг сайжруулж, ахлах сургууль, мэргэжлийн болон техникийн боловсрол, дээд боловсролын сургалтын байгууллагад зарим хичээлийг англи хэлээр заах боломжийг бүрдүүлнэ.



Төрийн өмчийн зарим их сургууль, политехник коллежийг түшиглэн техникийн болон дээд боловсролын шаталсан тогтолцоо бүхий сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн цогцолбор их сургууль, төрөлжсөн коллежийг бүсүүдэд хотхон хэлбэрээр хөгжүүлнэ.



Боловсрол, сургалтын үйл ажиллагаанд хиймэл оюун ухаан, дэвшилтэт технологи нэвтрүүлж, багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагч нарт зориулсан контент, сургалтын сан, платформ, мэдээллийн технологийн хөтөлбөр, агуулгыг боловсруулж, хиймэл оюунд суурилсан цахим сурах бичгийг хөгжүүлж, хүүхэд бүрд цахим төхөөрөмж олгоно.



Эдийн засгийн тэргүүлэх чиглэл, орон нутгийн хөгжлийн зорилттой уялдуулан мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг ажил олгогчийн шаардлага болон хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн, иргэдийг ажиллангаа суралцах, суралцангаа хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэн, хосмог ажлын байрны сургалтыг нэвтрүүлнэ.



Багшийн чанар, үнэлэмж, гүйцэтгэл, менежментийг сайжруулах "Сайн багшийг таны дэргэд" цогц арга хэмжээг Багшийн гурван тулгуурт бодлогын хүрээнд хэрэгжүүлнэ.



Багшийн хөдөлмөрийн бүтээмжийг бодитоор үнэлж, багш, ажилчдын цалин, хөдөлмөрийн хөлсний хэмжээг төсөв, мөнгөний бодлоготой уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлж, улсын дундаж хэмжээнд хүргэж, нийгмийн баталгааг хангана.



Багшийн мэргэжил дээшлүүлэх үндэсний тогтолцоог бэхжүүлэн, багшлах эрх олгох хялбаршуулсан сургалтын зохицуулалтыг бий болгож, багш бус мэргэжилтэй шилдэг боловсон хүчнийг багшаар бэлтгэх замаар хүний нөөцийн чадавхыг сайжруулж, багшийн хомсдолыг бууруулна.




Иргэдэд насан туршдаа суралцах тэгш боломжийг бүрдүүлж, нээлттэй боловсролын тогтолцоог хөгжүүлж, хүн бүрд орон зай, цаг хугацаанаас үл хамааран суралцах, боловсрол эзэмших тэгш хүртээмжтэй сургалтын контент, мэдээллийн системийг нэвтрүүлж, ур чадвар, чадамжийг дэмжсэн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлж, гэрчилгээ олгох, микро кредитийн сургалтыг холбогдох талуудтай хамтран хэрэгжүүлнэ.



БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

Бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан аймгуудын мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг төрөлжүүлж, зорилтот аймгуудад дадлага, үйлдвэрлэлийн бааз байгуулна.

Дадлага, үйлдвэрлэлийн бааз байгуулах байршил:



Улаанбаатарын бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг төрөлжүүлэн, сургалтын дэд бүтэц, салбар дундын дадлага, үйлдвэрлэлийн баазыг байгуулна.



1.2 ӨРСӨЛДӨХ ЧАДВАР

Зураг 1.1 Монгол Улсын хүний хөгжлийн индекс, сонгосон оноор



Эх үүсвэр: www.1212.mn




Хүний хөгжлийн индекс нь хүний чадавхийн хөгжлийг харуулах бөгөөд эрүүл саруул байж, урт удаан наслах; эрдэм мэдлэг эзэмших; амьжиргааны зохистой нөхцөлд аж төрөх гэсэн хүний амьдралын үндсэн гурван хэмжигдэхүүнийг илэрхийлнэ. Үүнд:


- Хүний амьдрах (наслах) хугацааг тодорхойлох үзүүлэлтийг төрөлтөөс тооцсон дундаж наслалтаар;
- Боловсролын байдлыг насанд хүрэгчдийн бичиг үсэг тайлагдалт болон бүх шатны боловсролд хамрагдалтын түвшингээр;
- Амьжиргааны зохистой түвшинг нэг хүнд ногдох ДНБ (худалдан авах чадварын паритетаар илэрхийлсэн доллар)-ээр тус тус тооцно.

Эх үүсвэр: 1212.mn


Зураг 1.2 Хүний хөгжлийг хэмжих гол үзүүлэлтийн индекс, тэдгээрийн өөрчлөлт



Зураг 1.3 Хүн амын боловсролын индекс, аймгаар, 2023 он



Зураг 1.4 Өрсөлдөх чадварын үзүүлэлт



Эх үүсвэр: IMD дэлхийн өрсөлдөх чадварын төв, МУ-ын эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

2024 онд Монгол Улсын өрсөлдөх чадвар эрэмбийн хувьд 67 улсаас 61-рт эрэмбэлэгдэж онооны хувьд 46.3 болж өмнөх жилээс 10.74 оноогоор нэмэгджээ. Ийнхүү эрэмбэ болон онооны хувьд сайжрахад эдийн засгийн эерэг үзүүлэлтүүд, институт болон нийгмийн үзүүлэлтүүд сайжирсан зэрэг нь түлхүү нөлөөлсөн байна.



Өрсөлдөх чадварыг энгийнээр тайлбарлавал хүмүүсийнхээ боловсрол, эрүүл мэнд, амьдралын чанарыг хангахын тулд өөрийн нөөц бололцоо, чадамжаа хэрхэн уялдаатай ашиглаж байгааг харуулах үзүүлэлт юм.

1.3

БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ТӨСӨВ,
САНХҮҮЖИЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Аливаа салбарын бодлогын амжилттай хэрэгжилт санхүүжилттэй салшгүй холбоотой.

2024
онд

ЦАХИМ БОЛОВСРОЛ, ХҮРТЭЭМЖ, ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛ


“Хүртээмжээс чанарт” зарчимд суурилсан санхүүжилтийг хэрэгжүүллээ. Боловсролын хууль тогтоомжийн шинэчлэл, цахим боловсрол, хүн бүрд чанартай боловсрол эзэмшүүлэх тэгш боломжийг бүрдүүлэх санхүүжилтийн хүрээнд бид ерөнхий боловсрол эзэмших Хувьсах зардлын бүтэц, бүрэлдэхүүнийг 1-12 дугаар анги бүрээр тооцон шинэчилж, математик, англи хэл, мэдээллийн технологийн хөтөлбөрүүдийг олон улсын жишигт нийцүүлж сайжруулах, цахим сургалтын орчныг бүрдүүлэх, шаардлагатай дэд бүтэц, үйлчилгээг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх, мэргэжлийн болон техникийн боловсролын мэргэжлийн өртөгт суурилсан хувьсах зардлын шинэчлэл, хэрэгжилтийг эхлүүлээ.

2025
онд

ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛ, ТЭГШ БОЛОМЖ, САЙН БАГШ ТАНЫ ДЭРГЭД

- **“Нүсэр биш төсөр”** зарчимд суурилсан санхүүжилтийг хэрэгжүүлнэ.
- Хувьсах зардлын бүтэц, бүрэлдэхүүнийг гарцад суурилан, хоол үйлдвэрлэлийн салбарын өртгийг тооцон шинэчилнэ.
- Боловсролын багц хуулийн хэрэгжилтийг хангах - сургалтын чанар, багшийн хөгжил, нийгмийн баталгааг хангаж, шилжүүлэн ажиллуулна.
- Сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, үндэсний хэмжээнд математик, англи хэл, мэдээллийн технологийн олон улсын хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- Хүүхэд бүрд хүртээмжтэй цахим сургалтын орчныг бий болгоно.
- Ачааллыг бууруулах хөрөнгө оруулалтыг эрчимжүүлж, School Mapping аргачлалаар төлөвлөж, HANSET бүсчилсэн хөгжлийн судалгаа, хиймэл оюун ухаанд суурилсан төлөвлөлтийг хэрэгжүүлнэ.
- Мэргэжлийн өөрийн өртөгт суурилсан хувьсах зардлын хэрэгжилтийг хангах, Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн төсвийг нэмэгдүүлж, хамрах хүрээг өргөжүүлнэ. Хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулан боловсон хүчин бэлтгэнэ.

Зураг 1.5 Боловсролын салбарын нийт төсөв, тэрбум төгрөг, 2021-2025 он



Тайлбар: 2024 онд Шинжлэх ухааны салбар Эдийн засаг, хөгжлийн яамны эрхлэх асуудлын хүрээнд шилжсэн.

Зураг 1.6 Боловсролын салбарын төсвийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь, 2021-2025 он



Тайлбар: Боловсролын салбарын төсөвт боловсролын удирдлага, болон бусад байгууллагын төсвийг оруулан тооцсон болно.

Зураг 1.7 Боловсролын салбарын төсвийн улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлогод эзлэх хувь, 2020-2025 он



Тайлбар: Боловсролын салбарын төсөвт боловсролын удирдлага, болон бусад байгууллагын төсвийг оруулан тооцсон болно.

1. БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

Сүүлийн 2 жилийн хугацаанд боловсролын салбарын төсвийн шинэчлэлийн хүрээнд нэг хүүхдэд ногдох хувьсах зардлаар тооцсон гүйцэтгэл үр дүнгийн санхүүжилтийг хэрэгжүүлж, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх, сургалтын чанар, хүртээмжийг сайжруулан, багшийн хөгжлийг дэмжлээ.

Боловсролын салбарын төсвийн үр ашиг сайжирснаар нийгмийн суурь салбаруудад төрийн үйлчилгээг чанартай хүргэж улмаар Монгол Улсын төсөв, эдийн засагт эерэг үр дүн авч ирэх юм.


Бүх шатны боловсролын чанар, хүртээмжийг дээшлүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэжлийн болон техникийн боловсрол олгох чиглэлээр салбарт зарцуулах санхүүжилтийг нэмэгдүүлж 2024 онд ДНБ-ий 5.7 хувьд хүргэлээ. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын салбарт гүйцэтгэлийн үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бүрэн хэрэгжүүлж, 2024 онд боловсролын салбарт зарцуулах төсөв улсын төсвийн нийт зарлагын 13.7 хувьд хүрлээ.

Хүснэгт 1.1 Боловсролын салбарын 2025 оны батлагдсан төсөв


Хөтөлбөр	Урсгал зардал	Хөрөнгийн зардал	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	Нийт дүн
				тэрбум төгрөг
Сургуулийн өмнөх боловсрол	1,153.4	-	-	1,153.4
Ерөнхий боловсрол	2,365.0	-	-	2,365.0
Дээд боловсрол	148.8	-	-2.07	146.7
Мэргэжлийн боловсрол	214.0	12.1	-	226.1
Шинжлэх ухаан, технологи	5.6	-	-	5.6
Насан туршийн боловсрол	13.1	-	-	13.1
Тусгай хэрэгцээт боловсрол	-	-	-	-
Боловсрол, ШУ-ны бодлого удирдлага	69.7	460.6	-	530.3
Боловсрол, ШУ-ны судалгаа шинжилгээ	23.9	-	-	23.9
Жендэрийн тэгш байдлыг хангах	0.0	-	-	0.0
Нийт	3,993.4	472.7	-2.1	4,464.0

Зураг 1.8 Хувьсах зардлын шинэчлэл


Суурь хувьсах зардлын өөрчлөлт



Бусад хувьсах зардлын өөрчлөлт



Зураг 1.9 Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээ




1.4

МОНГОЛ УЛСЫН БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД БОЛОВСРОЛЫН САЛБАРТ ХИЙГДЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН УРЬДЧИЛСАН ТӨСӨӨЛӨЛ


Зураг 1.10 Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд төрөлжсөн ахлах сургууль барих



Зураг 1.11 Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд мэргэжлийн болон дээд боловсролын сургалтын цогцолбор барих:




Зураг 1.12 Зарим ачаалал өндөр байршлуудад шинээр барих сургууль, өргөтгөл, газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн хүчитгэл



Зураг 1.13 2025 оны хөрөнгө оруулалт:




Зураг 1.14 Боловсролын салбарын төсвийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь



Эх үүсвэр: <https://data.worldbank.org/indicator/SE.XPD.PRIM.PC.ZS?view=chart>

Зураг 1.15 Боловсролд зарцуулж буй зардлын харьцуулсан үзүүлэлт

- 2022 оны байдлаар нэг хүүхдэд зарцуулах боловсролын хуримтлагдсан зардал нь 75,000 ам.доллар болон түүнээс дээш улсууд
- 2022 оны байдлаар нэг хүүхдэд зарцуулах боловсролын хуримтлагдсан зардал нь 75,000 ам.доллараас доош улсууд




Сургалтын зохих хугацаанд нэг сурагчид ногдох хуримтлагдсан зардал (ам.доллар)

Эх үүсвэр: "Писа-2022" үндэсний тайлангаас.



Зураг 1.16 Боловсролын салбарын төсвийн улсын нийт төсөвт эзлэх хувь



Эх үүсвэр: <https://data.worldbank.org/indicator/SE.XPD.PRIM.PC.ZS?view=chart>




02


БОЛОВСРОЛЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

2.1 БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА

Зураг 2.1 Бүх түвшний боловсролын сургалтын байгууллага, хичээлийн жилийн эхэнд




Зураг 2.2 Бүх түвшний боловсролын сургалтын байгууллага, өмчийн хэлбэр, байршлаар, 2024-2025




2.2 БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН СУРАЛЦАГЧ

Зураг 2.3 Бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын суралцагчид, хичээлийн жилийн эхэнд




Зураг 2.4 Бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын суралцагчид, хичээлийн жилийн эхэнд, хүйсээр



Зураг 2.5 Бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын суралцагчид, хүйсээр, 2024-2025



Зураг 2.6 Бүх түвшний боловсролын сургалтын байгууллагыг төгсөгчид, 2023/2024



Хүснэгт 2.1 Төгсөгчид ба шинэ элсэгчид


	2021/2022	2022/2023	2023/2024	2024/2025
Ерөнхий боловсролын сургуулийн суурь боловсролтой нийт төгсөгчид	53,619	59,593	64,365	-
Ерөнхий боловсролын сургуулийн суурь боловсролтой төгсөгчдөөс 10-р ангид элсэгчдийн эзлэх хувь	79.4	72.7	83.0	82.0
Ерөнхий боловсролын сургуулийн суурь боловсролтой төгсөгчдөөс МБТБ-ын байгууллагад элсэгчдийн эзлэх хувь	17.3	14.6	15.5	15.4
Ерөнхий боловсролын сургуулийн бүрэн дунд боловсролтой нийт төгсөгчид	32,908	33,135	36,620	-
Ерөнхий боловсролын сургуулийн бүрэн дунд боловсролтой төгсөгчдөөс МБТБ-ын байгууллагад элсэгчдийн эзлэх хувь	4.4	4.1	6.9	6.9
Ерөнхий боловсролын сургуулийн бүрэн дунд боловсролтой төгсөгчдөөс дээд боловсролын сургалтын байгууллагад элсэгчдийн эзлэх хувь	70.4	60.3	52.3	51.6

2.3 БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН БАГШ, АЖИЛЛАГЧИД

Хүснэгт 2.2 Нийт үндсэн багш, ажиллагчид, байгууллагын ангиллаар, мянган хүн

	Ажиллагчид				Үүнээс: Үндсэн багш			
	2021/ 2022	2022/ 2023	2022/ 2023	2024/ 2025	2021/ 2022	2022/ 2023	2023/ 2024	2024/ 2025
Нийт	103.3	106.2	109.3	111.6	52.1	53.0	54.2	55.0
Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллага	12.2	32.5	34.0	35.3	8.8	9.4	9.7	9.9
Ерөнхий боловсролын сургууль	56.2	57.7	59.5	61.0	35.1	36.1	37.0	37.8
Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага	3.9	4.1	4.2	3.9	2.1	2.3	2.4	2.1
Дээд боловсролын сургалтын байгууллага	31.0	11.9	11.7	11.4	6.1	5.2	5.1	5.2

Зураг 2.7 Нийт үндсэн багш, хүйс, өмчийн хэлбэр, боловсролын сургалтын байгууллагаар, 2024-2025



	Нийт үндсэн багш 55,006	Төрийн	Хувийн	Эмэгтэй	Эрэгтэй
Дээд	5,151	3,308	1,843	2,008	3,143
МБТБ	2,140	1,700	440	749	1,391
ЕБС	37,770	32,728	5,042	6,609	31,161
СӨБ	9,945	8,768	1,177	9,496	449




2.4 ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД*

Хүснэгт 2.3 ЕБС-ийн багшийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүн, аймаг, дүүргээр 2023/2024

Аймаг	Бага боловсрол	Суурь боловсрол	Бүрэн дунд боловсрол
Архангай	77.0	76.2	76.6
Баян-Өлгий	72.3	75.2	76.3
Баянхонгор	77.8	77.4	77.6
Булган	73.5	75.3	73.7
Говь-Алтай	76.1	77.2	76.5
Говь-Сүмбэр	78.9	78.5	75.8
Дархан-Уул	76.8	76.1	76.9
Дорноговь	70.6	71.8	70.9
Дорнод	74.4	77.0	74.7
Дундговь	75.6	76.4	75.4
Завхан	78.3	79.5	78.0
Орхон	74.6	77.4	76.4
Өвөрхангай	77.6	79.2	77.6
Өмнөговь	76.4	74.2	74.9
Сүхбаатар	76.5	77.0	75.5
Сэлэнгэ	74.9	76.5	76.5
Төв	75.7	74.8	75.2
Увс	79.8	82.0	81.3
Ховд	77.4	77.1	77.5
Хөвсгөл	78.1	78.3	77.4
Хэнтий	76.7	75.8	75.6
Дүүрэг	Бага боловсрол	Суурь боловсрол	Бүрэн дунд боловсрол
Багануур	75.1	77.1	75.0
Багахангай	85.6	76.8	82.5
Баянгол	78.1	78.3	78.3
Баянзүрх	78.1	78.0	77.8
Налайх	82.2	81.7	81.7
Сонгинохайрхан	76.5	78.8	76.8
Сүхбаатар	79.2	79.0	78.3
Хан-Уул	77.9	77.1	78.0
Чингэлтэй	77.2	79.4	78.4

Зураг 2.8 ЕБС-ийн багшийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүн /суралцагчдын бичгийн шалгалтын үр дүн /2023/2024




Эх үүсвэр: *Боловсролын үнэлгээний төв

2. БОЛОВСРОЛЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ


Зураг 2.9 СӨБ-ын багшийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүн (хүүхдийн хөгжлийн үнэлгээний үр дүн), 2023/2024




Зураг 2.10 СӨБ-ын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүн, хүүхдийн хөгжлийн гүйцэтгэлээр, 2023/2024



Зураг 2.11 СӨБ-ын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүн, аймагтар, 2023/2024



Зураг 2.12 СӨБ-ын хүүхдийн хөгжлийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүн, 2023/2024





03

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ

2024 оны ОНЦЛОХ АЖИЛ:

Засгийн газрын бүрэн эрхийн хүрээнд үндэсний сургалтын хөтөлбөрүүдийн залгамж холбоотой, тогтвортой байх нөхцөлийг хангах зорилгоор “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал”-ыг 2024 онд батлуулсан.

Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт нь төлөвлөх, боловсруулах, турших, сайжруулах, хэрэгжүүлэх, үнэлэх үйл явцыг багтаасан тасралтгүй, цогц үйл ажиллагаа байдаг. Иймд 2024 онд хөтөлбөрийн шинэчлэлийг эхлүүлж, сургуулийн өмнөх болон бага боловсролын хөтөлбөрийг боловсруулж, туршин, үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх бэлтгэлийг хангаж байна. Туршилтыг 18 цэцэрлэг, 27 ерөнхий боловсролын сургуулийн хүрээнд хэрэгжүүлж, хөтөлбөрийн тохирцыг тогтоохоор ажиллаж байна.

Сургуулийн өмнөх боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд салбар бүлэгтэй цэцэрлэгийн бүлгийн тооноос хамаарсан итгэлцүүрийг шинээр боловсруулан тусгаж, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын байршил, хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүрийг нийслэл, аймгийн төв, сум гэсэн 3 ялгаатай байршлаар шинэчлэн тогтоож өгсөн. Түүнчлэн бүсчилсэн хөгжлийн бодлого, шаталсан сургалтын тогтолцоотой уялдуулан урлаг, спортын төрөлжсөн ерөнхий боловсролын сургуулийн нэмэлт хөтөлбөрийн болон сургуулийн өмнөх, бага боловсролын хөтөлбөрийн шинэчлэлтэй уялдуулан туршилт хийх түшиц сургуулийн итгэлцүүрийг хэрэглэж байна.

2024-2025 оны хичээлийн жилээс эхлэн бид нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 4000 төгрөг, уртасгасан цагийн зохицуулалттай 24 цагийн цэцэрлэг, цэцэрлэгийн бүлгийн хүүхэд болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 5100 төгрөг байхаар шинэчлэн тогтоосон.

Хүүхдийн эрүүл мэнд, өсөлт, хөгжилтөд дэмжлэг болохуйц чанартай хоол идэх, хоолны орц найрлага, шим тэжээлийг нэмэгдүүлэхэд эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хувь нэмрээ оруулах Засгийн газрын тогтоолыг батлуулж, уг хэрэгжилтэд цахим системийг ашиглаж байна.

Хүснэгт 3.1 Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үндсэн үзүүлэлт, 2024-2025


Үзүүлэлт	Бүгд	Хот	Орон нутаг	Төрийн өмчийн	Хувийн өмчийн
Цэцэрлэгийн тоо	1,407	655	752	1,024	383
Ердийн	1,407	655	752	1,024	383
Тусгай	-	-	-	-	-
Бүлгийн тоо	9,226	4,376	4,850	7,776	1,450
Үндсэн	8,799	4,376	4,423	7,349	1,450
Хувилбарт	427	-	427	427	-
Сургуулийн өмнөх боловсролд хамрагдагчид	264,818	125,429	139,389	234,556	30,262
Эмэгтэй	129,476	61,565	67,911	114,661	14,815
Эрэгтэй	135,342	63,864	71,478	119,895	15,447
Цэцэрлэгт	253,158	125,429	127,729	222,896	30,262
Эмэгтэй	124,211	61,565	62,646	109,396	14,815
Эрэгтэй	128,947	63,864	65,083	113,500	15,447
Хувилбарт	11,660	-	11,660	11,660	-
Эмэгтэй	5,265	-	5,265	5,265	-
Эрэгтэй	6,395	-	6,395	6,395	-
Халамжид буй хүүхэд	3,779	1,427	2,352	3,581	198
Эмэгтэй	1,701	629	1,072	1,603	98
Эрэгтэй	2,078	798	1,280	1,978	100
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд	2,150	1,199	951	1,925	225
Эмэгтэй	747	388	359	664	83
Эрэгтэй	1,403	811	592	1,261	142
Малчдын хүүхэд	32,282	1,232	31,050	31,883	399
Эмэгтэй	15,582	599	14,983	15,413	169
Эрэгтэй	16,700	633	16,067	16,470	230
Нийт багш, ажиллагчид	35,339	15,872	19,467	30,163	5,176
Эмэгтэй	29,998	13,839	16,159	25,333	4,665
Эрэгтэй	5,341	2,033	3,308	4,830	511
Үндсэн багшийн тоо	9,945	4,563	5,382	8,768	1,177
Эмэгтэй	9,496	4,336	5,160	8,342	1,154
Эрэгтэй	449	227	222	426	23
Туслах багшийн тоо	8,743	4,353	4,390	7,562	1,181
Эмэгтэй	8,730	4,346	4,384	7,557	1,173
Эрэгтэй	13	7	6	5	8
Цэцэрлэгийн бүлэг дүүргэлт /Улсын дундаж/	28.7	28.7	28.7	29.7	22.8
Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын цэвэр жин /2-5 нас/	90.6	94.1	89.6	-	-

3.1 СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА

Монгол Улсын хэмжээнд 2024-2025 оны хичээлийн жилд нийт **1,407 цэцэрлэгт 264,818 хүүхэд** сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж, **35,339** багш, ажиллагчид ажиллаж байна.



Зураг 3.1 Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллага, хүүхдийн тоо




Монгол Улсын хэмжээнд 2024-2025 оны хичээлийн жилд нийт **1,407 хүүхдийн цэцэрлэг** үйл ажиллагаа явуулж байгаагийн **1,024 нь** төрийн өмчийн, **383 нь** хувийн өмчийн цэцэрлэг байна.




“Хүүхдийн цэцэрлэг” гэж /цаашид “цэцэрлэг” гэх/ хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих сургалтын байгууллагыг ойлгоно.

3. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ


Зураг 3.2 Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллага, өмчийн хэлбэр, байршлаар



Зураг 3.3 Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллага, өмчийн хэлбэр, байршлаар, 2024/2025



Зураг 3.4 Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагын бүлэг, сургалтын хэлбэрээр



"Сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалт" (цаашид "хувилбарт сургалт" гэх) гэж оршин суудаг газар болон хөгжлийн бэрхшээлийн улмаас цэцэрлэгийн үндсэн бүлгийн сургалтад тогтмол хамрагдах боломжгүй сургуулийн өмнөх насны хүүхдэд боловсрол эзэмшүүлэх сургалт, үйл ажиллагааг ойлгоно.


3.2 СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН БҮЛЭГ

Хүснэгт 3.2 Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагын бүлэг, өмчийн хэлбэрээр

Хичээлийн жил	Бүлгийн тоо	Төрийн өмч	Үүнээс:		Хувийн өмч	Үүнээс:	
			Цэцэрлэгт	Хувилбарт		Цэцэрлэгт	Хувилбарт
2021-2022	8,419	6,965	6,481	484	1,454	1,454	-
2022-2023	8,871	7,448	6,992	456	1,423	1,423	-
2023-2024	9,034	7,682	7,257	425	1,352	1,352	-
2024-2025	9,226	7,776	7,349	427	1,450	1,450	-


“Бүлэг дүүргэлт” гэж нэг бүлэгт суралцаж байгаа хүүхдийн тоог хэлнэ.

Зураг 3.5 Бүлэг дүүргэлтийн улсын дундаж



Улсын хэмжээнд сургуулийн өмнөх боловсролын байгууллагын бүлэг дүүргэлтийн улсын дундаж **2024-2025 оны** хичээлийн жилд **28.7** байна.

Зураг 3.6 Бүлэг дүүргэлтийн дундаж, анги, өмчийн хэлбэр, байршил, сургалтын хэлбэр



Улсын хэмжээнд цэцэрлэгийн үндсэн сургалтын бүлэг дүүргэлтийн дундаж **28.8** байна. Харин төрийн өмчийн цэцэрлэгийн хувьд **29.7** байгаа нь хувийн цэцэрлэгээс **6.8** пунктээр дээгүүр байна.


3.3 СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛД ХАМРАГДАЖ БУЙ ХҮҮХДИЙН ТОО

Хүснэгт 3.3 Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй хүүхдийн тоо, өмчийн болон сургалтын хэлбэр

Хичээлийн жил	Хүүхдийн тоо	Үндсэн сургалт	Хувилбарт сургалт	Төрийн өмчийн цэцэрлэгт	Хувийн өмчийн цэцэрлэгт		
					Үндсэн	Хувилбарт	
2021/2022	237,231	222,517	14,714	204,639	189,925	14,714	32,592
2022/2023	266,024	250,457	15,567	231,583	216,016	15,567	34,441
2023-2024	274,236	260,271	13,965	242,109	228,144	13,965	32,127
2024/2025	264,818	253,158	11,660	234,556	222,896	11,660	30,262

Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд 2024-2025 оны хичээлийн жилд нийт **264,818** хүүхэд хамрагдаж байгаа бөгөөд хамран сургалт **90.6** хувьд хүрсэн нь өмнөх хичээлийн жилээс **0.9** пунктээр өссөн байна.

Зураг 3.7 Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй хүүхдийн тоо, бүлгээр, 2024/2025



Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/224 дугаар тушаалаар "Сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалт зохион байгуулах журам"-ыг баталсан.

"Нүүдлийн бүлгийн" гэж хувилбарт сургалтад хамрагдсан хүүхэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх зорилгоор тогтоосон хугацаанд төвлөрүүлэн зохион байгуулах танхимын сургалт, үйл ажиллагааг ойлгоно.

"Гэр бүлд суурилсан" гэж хувилбарт сургалтад хамрагдсан хүүхдийн хөгжлийг гэр бүлийн орчинд эцэг эх, асран хамгаалагчийн дэмжлэгт тулгуурлан багшийн чиглүүлэг, зөвлөмжөөр хэрэгжүүлэх /явуулын/ зайн сургалтыг ойлгоно.


САЛБАРЫН ОНЦЛОГ: СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ

2022/2023 оны хичээлийн жилээс эхлэн цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг улсын хэмжээнд хэрэгжүүлж, сургуулийн өмнөх насны хүүхэд бүрийг үйлчилгээнд хамруулах зорилт тавин амжилттай ажиллаж байна.

2024-2025 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан **3-5 насны хүүхдийн хамран сургалт** улсын хэмжээнд **92.9** хувьтай байна.




Зураг 3.8 Монгол Улсын 2-5 насны хүн амын 2050 он хүртэлх өсөлтийн урьдчилсан төлөв байдал



Тайлбар: 2022 оны хүн амыг ҮСХ-ны 2021 оны суурин хүн амыг нас дэвшүүлж тооцон гаргасан.

Эх үүсвэр: 2023-2050 оны хэтийн тооцоог БШУЯ, ҮСХ-ны "Боловсролын хэтийн тооцоо 2020-2050 он" тайлангаас авсан.

Зураг 3.9 Хувийн өмчийн цэцэрлэгийн тоо, түүнд хамрагдаж буй хүүхдийн тоо



5 НАСТАЙ ХҮҮХДИЙН ХАМРАН СУРГАЛТ

Зураг 3.10 Таван настай хүүхдийн сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт



Тайлбар: 2023 оны 5 настай хүүхдийн тоог УСХ-ны 2023 оны суурин хүн амын тоог нас дэвшүүлэн тооцсон.

5 настай хүүхдийн хамран сургалтын цэвэр жин 2024-2025 оны хичээлийн жилд **94.1** байгаа нь өмнөх оны хичээлийн жилээс 1.7 пунктээр өссөн байна.




СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН ХАМРАГДАЛТ, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН БОДЛОГО:

Сургуулийн өмнөх боловсролын хамрагдалтыг нэмэгдүүлж, 5 настай бүх хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд заавал хамруулахын зэрэгцээ малчдын болон ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг тэгш хамруулах, хөгжлийг дэмжих бодлогыг хэрэгжүүлж байна.

Цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд байгууллагын дэргэдэх цэцэрлэгийг байгуулахад төрөөс мэргэжлийн удирдлага, нэг хүүхдэд ногдох хувьсах зардал, хүүхдийн хоолны зардал, мэргэжлийн багшаар хангах, багшийн мэргэжлийг дээшлүүлэх үйл ажиллагааны дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.


Зураг 3.11 Таван настай хүүхдийн хамран сургалтын цэвэр жин, аймгаар, 2024-2025



Зураг 3.12 Таван настай хүүхдийн хамран сургалтын цэвэр жин, дүүргээр, 2024-2025






Зураг 3.13 Сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан таван настай хүүхдийн тоо, сургалтын хэлбэрээр, 2024-2025



3.4 СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН ХАМРАН СУРГАЛТ


Зураг 3.14 2-5 настай нийт хүүхдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй байдал



Монгол Улсын Засгийн газраас санаачлан цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг 2022-2023 оны хичээлийн жилээс эхлэн Улаанбаатар хотод хэрэгжүүлсэн бөгөөд улсын хэмжээнд хэрэгжүүлэн хамран сургалт **90.6** хувьд хүрсэн.


Үүний үр дүнд 2024-2025 оны хичээлийн жилд 3-5 насны хүүхдийн **92.9** хувь нь сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж өмнөх жилээс **0.1** пунктээр өссөн байна.

Зураг 3.15 2-5 настай хүүхдийн хамран сургалтын цэвэр жин ба ажилгүйдэл, ядуурлын түвшний харьцуулалт, бүсээр, хувиар




Эх үүсвэр: Ядуурлын үр дүнг УСХ-ны ӨНЭЗС-ны 2020 оны үр дүнгээс авсан.
Ажилгүйдлийн түвшинг УСХ-ны 2022 оны АХС-ны жилийн эцсийн тайлангийн үр дүнгээс авсан.

Зураг 3.16 2-5 насны нийт хүүхдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан болон хамрагдаагүй хүүхдийн эзлэх хувь, аймгаар, 2024-2025




Зураг 3.17 Сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан малчдын болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо






Зураг 3.18 Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, хөгжлийн бэрхшээлийн төрлөөр, 2024-2025




Зураг 3.19 Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй малчдын хүүхэд, аймгаар, 2024-2025




3.5 СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН БАГШ, АЖИЛЛАГЧИД


Зураг 3.20 Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагын нийт багш, ажиллагчид, өмчийн хэлбэрээр



Зураг 3.21 Төрийн өмчийн сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагын нийт багш, ажиллагчид, байршлаар




Зураг 3.22 Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагад ажиллаж байгаа үндсэн багш болон багшийн туслахын тоо, 2024-2025




Хүснэгт 3.4 Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагад ажиллаж байгаа нийт үндсэн багшийн боловсролын түвшин

Хичээлийн жил	Мэргэжлийн багшийн хангалт	Боловсролын түвшин:				
		Доктор	Магистр	Бакалавр	Диплом	Бусад
2021/2022	97.2	-	794	7,240	545	245
2022/2023	93.3	-	1,118	7,263	433	636
2023/2024	92.0	-	1,170	7,389	392	782
2024/2025	93.5	0	1,232	7,710	353	650

Зураг 3.23 Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагад ажиллаж байгаа үндсэн багш, насны бүлэг, ажилласан жилээр, 2024-2025



Зураг 3.24 СӨБ-ын нэг багшид ногдох хүүхдийн тоо, аймаг, нийслэл, дүүргээр, 2024-2025



Сургуулийн өмнөх боловсролын нэг үндсэн багшид улсын дунджаар **29.0** хүүхэд ногдож байна. Нэг багшид ногдох хүүхдийн тоогоор хамгийн бага нь Сэлэнгэ (**23.5**), хамгийн өндөр нь Өмнөговь (33,6), Говьсүмбэр (**31.9**) аймаг байна.

Нийслэлийн хувьд сургуулийн өмнөх боловсролын нэг үндсэн багшид ногдох хүүхэд хамгийн өндөр нь Баянзүрх дүүрэг (**31.8**), хамгийн бага нь Багануур дүүрэг (**22.5**) байна.



СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН ЦАХИМ ШИЛЖИЛТ

Боловсролын ерөнхий хуулийн 40.2.9 дэх заалт, МУЗГ-ын “Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2024 оны 73 дугаартай тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүүхдийн хоолны түүхий эдийн зардлыг эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс татан төвлөрүүлэх системд тавих техникийн шаардлага”-г ТНБД баталж тус шаардлагад нийцсэн 5 хоол үйлдвэрлэл, үйлчилгээний систем хөгжүүлэгч байгууллагыг БМТТ-ийн цахим хуудсанд нээлттэй байршуулсан. Үүнээс цэцэрлэгийн зөвлөл сонголт хийж, системийг ашиглаж, ашиглалт, үйлчилгээний зардлыг хувьсах зардлын цахим хэрэглээний зардлаас санхүүжүүлдэг болсон. 12 дугаар сарын байдлаар нийслэлийн төрийн өмчийн 305 цэцэрлэг хоолны түүхий эдийн зардлыг хүүхдийн ирцэд тулгуурлан эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс татан төвлөрүүлж байна.



04

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ

Тэгш хамран сургах боловсролын чиглэлээр 45 гаруй мянган багшийг сургаад байна. Түүнчлэн ерөнхий боловсролын сургуулийн багшийн туслахын чиг үүрэгт сургуулийн орчинд хүүхэд болзошгүй эрсдэлд өртөхөөс хамгаалахаас гадна ялгаатай хэрэгцээтэй хүүхдэд дэмжлэг үзүүлэх, дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх мэргэжлийн чиглэл, индексэд “Хэл засалч” мэргэжлийн индексийн оруулж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол олгох хэл засалч, хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч, сэтгэл зүйч, арга зүйч мэргэжлийн үндсэн хөтөлбөрөөр суралцагчид гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцахад тэтгэлэг, сургалтын зээл, буцалтгүй тусламж, дэмжлэг авах боломжтой боллоо.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд “Ерөнхий боловсролын сурах бичиг нь хэвлэмэл, цахим хэлбэртэй байна” гэж заасан. Та бүхэн мэдэж байгаачлан, 12 сарын 06-нд бага ангийн сурагчдын цүнхний жинг багасгаж, дасгал, даалгавруудыг илүү сонирхолтой, интерактив, бүтээлч болгох зорилгоор Боловсролын яам Польшийн “Learnetic” компанийн техникийн дэмжлэгтэйгээр I-V ангийн есөн төрлийн сурах бичгийг дижитал хэлбэрт шилжүүлснийг хүлээн авсан. Ингэснээр бага ангийн 33 сурах бичгийн агуулга, дасгал, даалгаврыг интерактив хэлбэрт хөрвүүлж, 13,500 орчим дасгал, даалгаврын сантай болсон.

Бүлэг дүүргэлт, багшийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалан хөдөөгийн сургуулийн ахлах ангийн суралцагчдын дунд үүсдэг бэрхшээлийг арилгах, тэдэнд сонгон судлах хичээлээ судлах тэгш боломж олгох, хилийн чанадад байгаа монгол хүүхдэд монгол хэл, монголын түүх, соёл, үндэсний өв уламжлал, зан заншлаас сургах зорилгоор цахим сургуулийн үйл ажиллагааг 2022-2023 оны хичээлийн жилд туршилтаар БМТТ-ийн дэргэд эхлүүлсэн. 2024-2025 оны хичээлийн жилд ахлах ангийн сонгон судлах хичээлийн бүлэг бүрдээгүй 432 /нийслэл-114, аймгийн төв-102, сум-207, баг-8, Солонгос улс дахь-1/ сургуулийн 10-р ангийн 7,074, 11-р ангийн 5,531 сурагч, 12-р ангийн 4,848 сурагч, нийт 17,453 суралцагч цахим сургуульд суралцаж байна.

Боловсролын хууль тогтоомжийн шинэчлэл, цахим боловсрол, хүн бүрд чанартай боловсрол эзэмшүүлэх тэгш боломжийг бүрдүүлэх санхүүжилтийн хүрээнд бид ерөнхий боловсрол эзэмших Хувьсах зардлын бүтэц, бүрэлдэхүүнийг 1-12 дугаар анги бүрээр тооцон шинэчилж, математик, англи хэл, мэдээллийн технологийн хөтөлбөрүүдийг олон улсын жишигт нийцүүлж сайжруулах, цахим сургалтын орчныг бүрдүүлэх, шаардлагатай дэд бүтэц, үйлчилгээг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх, мэргэжлийн болон техникийн боловсрол мэргэжлийн өртөгт суурилсан хувьсах зардлын шинэчлэл, хэрэгжилтийг эхлүүллээ.

Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад монгол хэлний элсэлтийн шалгалтыг 10 дугаар ангиасаа өгөх боломжийг бүрдүүллээ.



Хүснэгт 4.1 Ерөнхий боловсролын үндсэн үзүүлэлт, 2024-2025

Үзүүлэлт	Бүгд	Хот	Орон нутаг	Төрийн өмчийн	Хувийн өмчийн
Сургууль	885	513	372	705	180
Бага сургуулийн тоо /1-5-р ангитай/	72	33	39	45	27
Дунд сургуулийн тоо /1-9, 6-9-р ангитай/	109	11	98	106	3
Ахлах сургуулийн тоо /1-12, 10-12-р ангитай/	694	453	241	544	150
Цогцолбор сургуулийн тоо	10	7	3	10	-
Засгийн газрын хоорондын гэрээний дагуу байгуулагдсан	2	2	-	2	-
3 ээлжтэй сургуулийн тоо	8	6	2	8	-
3 ээлжинд хичээллэдэг бүлэг	56	46	10	56	-
3 ээлжинд хичээллэж буй суралцагчид	2,120	1,792	328	2,120	-
Бага анги	2,120	1,793	327	2,120	-
Дунд анги	-	-	-	-	-
Ахлах анги	-	-	-	-	-
Бүлгийн тоо	26,228	11,983	14,245	22,815	3,413
Бага анги	12,182	5,583	6,599	10,545	1,637
Дунд анги	8,931	4,051	4,880	7,865	1,066
Ахлах анги	5,115	2,349	2,766	4,405	710
Суралцагчид	802,327	397,930	404,397	726,175	76,152
Эмэгтэй	397,747	197,338	200,409	359,896	37,851
Эрэгтэй	404,580	200,592	203,988	366,279	38,301
Суралцагч /өдөр/	797,905	397,338	400,567	721,758	76,147
Эмэгтэй	396,663	197,123	199,540	358,815	37,848
Эрэгтэй	401,242	200,215	201,027	362,943	38,299
Нөхөн олгох хөтөлбөрөөр хичээллэж буй суралцагч	4,422	592	3,830	4,417	5
Эмэгтэй	1,084	215	869	1,081	3
Эрэгтэй	3,338	377	2,961	3,336	2
Нэгдүгээр ангид шинээр элсэгч	74,367	37,180	37,187	66,802	7,565
Эмэгтэй	36,202	18,107	18,095	32,375	3,827
Эрэгтэй	38,165	19,073	19,092	34,427	3,738
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд	6,273	3,255	3,018	6,162	111
Эмэгтэй	2,402	1,153	1,249	2,365	37
Эрэгтэй	3,871	2,102	1,769	3,797	74
Малчдын хүүхэд	136,730	11,023	125,707	135,915	815
Эмэгтэй	68,918	5,771	63,147	68,561	357
Эрэгтэй	67,812	5,252	62,560	67,354	458
Дотуур байртай сургуулийн тоо	526	14	512	516	10
Дотуур байрны тоо	526	14	512	516	10
Дотуур байранд амьдарч буй хүүхэд	35,486	1,409	34,077	34,447	1,039
Эмэгтэй	18,220	829	17,391	17,792	428
Эрэгтэй	17,266	580	16,686	16,655	611
Нийт багш, ажиллагчид	61,016	24,512	36,504	53,397	7,619
Эмэгтэй	48,363	19,843	28,520	42,402	5,961
Эрэгтэй	12,653	4,669	7,984	10,995	1,658
Үндсэн багшийн тоо	37,770	17,061	20,709	32,728	5,042
Эмэгтэй	31,161	14,368	16,793	27,127	4,034
Эрэгтэй	6,609	2,693	3,916	5,601	1,008
Бага боловсролын хамран сургалтын цэвэр жин /1-5/	97.7	96.8	98.6		
Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин /1-9/	97.0	96.7	95.4		
ЕБС-ийн бүлэг дүүргэлт	30.4	33.2	28.1	31.6	22.3

Тайлбар: Энэ хүснэгтэд байгаа зарим үзүүлэлтийн хот, хөдөөгийн ангилал нь БДБ-ын шинэчлэгдсэн маягтын хүрээнд УХС-ны Хүн ам, орон сууцны тооллогын хот, хөдөөгийн ангилал кодыг дагаж мөрдсөн гэдгийг анхаарна уу. Улаанбаатар болон хот гэсэн ангилал нь тусдаа үзүүлэлтүүд гэдгийг анхаарна уу.


4.1 ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ

Зураг 4.1 Ерөнхий боловсролын сургуулийн тоо, өмчийн хэлбэрээр



Улсын хэмжээнд 2024-2025 оны хичээлийн жилд нийт **885** ерөнхий боловсролын сургуулийн **26,228** бүлэгт **798.9** мянган суралцагчид (өдрөөр) суралцаж, нийт **61.0** мянган багш, ажиллагчид ажиллаж байна.

Зураг 4.2 Ерөнхий боловсролын сургуулийн тоо, бүтцээр



Сургуулийн бүтцийн статистик мэдээлэл нь Боловсролын салбарын багц хууль шинэчлэгдэхээс өмнөх мэдээлэл гэдгийг анхаарна уу.


Зураг 4.3 Ерөнхий боловсролын сургуулийн тоо, бүтцээр, 2024-2025



Сургуулийн бүтцийн статистик мэдээлэл нь Боловсролын салбарын багц хууль шинэчлэгдэхээс өмнөх мэдээлэл гэдгийг анхаарна уу.

Төрийн өмчийн сургуулиудын **45 (6.4%)** нь бага сургууль, **106 (15.0%)** нь дунд сургууль, **544 (77.2%)** нь ахлах сургууль, **10 (1.4%)** нь цогцолбор сургууль байна.

Зураг 4.4 Ерөнхий боловсролын сургуулийн тоо, байршлаар




Хүснэгт 4.2 Ерөнхий боловсролын сургуулийн тоо

	2021-2022	2022-2023	2024-2025	2024-2025
Нийт сургуулийн тоо	848	859	871	885
Ердийн	741	753	769	693
Мэргэжлийн /төрөлжсөн/	16	17	23	154
Гүнзгийрүүлсэн /холимог/	73	70	43	3
Тусгай	6	6	6	7
Олон улсын хөтөлбөртэй	12	13	28	28

Хүснэгт 4.3 Ерөнхий боловсролын сургуулийн тоо, бүтэц, байршлаар, 2024-2025

Байршил	Улсын хэмжээнд					Төрийн өмчийн				
	Бүгд	Бага	Дунд	Ахлах	Цогцолбор	Бүгд	Бага	Дунд	Ахлах	Цогцолбор
Баг	52	30	6	13	3	52	30	6	13	3
Сум	339	2	96	241		337	1	96	240	
Аймаг	176	7	0	167	2	150	3		145	2
Нийслэл	314	33	7	269	5	163	11	4	143	5
Бусад /Олон улсын болон БНСУ дахь сургууль/	4	-	-	4	-	3	-	-	3	-
Нийт	885	72	109	694	10	705	45	106	544	10

Зураг 4.5 Ерөнхий боловсролын сургуулийн тоо, хичээллэж байгаа ээлжээр, 2024-2025




Нийт **885** сургуулийн **376 (42.5%)** нь **1** ээлжээр, **509 (57.5%)** нь **2** ээлжээр хичээллэж байна.



Зураг 4.6 Ерөнхий боловсролын сургуулийн тоо, байршил, бүтцээр, 2024-2025




Зураг 4.7 Ерөнхий боловсролын сургуулийн тоо, аймгаар, 2024-2025



Хүснэгт 4.4 Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн тооны тархалт, 2024-2025


Суралцагчийн тооны тархалт	Багийн төв	Сумын төв	Аймгийн төв	Нийслэл	Бусад	Нийт
0-499	38	212	49	128	4	431
500-699		66	14	24		104
700-999		33	24	35		92
1000-1499		27	40	24		91
1500-1999		7	24	24		55
2000-2999			25	42		67
3000-4499			6	27		33
4500+			2	10		12
Нийт	38	345	184	314	4	885

Зураг 4.8 100 ба түүнээс доош суралцагчтай сургуулийн тоо, байршлаар, 2024-2025



4.2 ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН БҮЛЭГ


Зураг 4.9 Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн бүлгийн тоо



2024-2025 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн нийт бүлэг **26,228** байгаагийн **70.7** хувь нь нэг ээлжээр, **29.3** хувь нь хоёр ээлжээр хичээллэж байна.




Зураг 4.10 Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн бүлгийн тоо, ээлжээр



4. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ

Зураг 4.11 Бүлэг дүүргэлт




Бүлэг дүүргэлтийн улсын дундаж төрийн өмчийн сургуульд **31.6** байгаа нь хувийн өмчийн сургуулиас **9.3** пунктээр өндөр байна. Хотод бүлэг дүүргэлт **33.2** байгаа нь орон нутгийн бүлэг дүүргэлтээс **5.1** пунктээр өндөр байна.


“Бүлэг дүүргэлт” гэж нэг бүлэгт суралцаж байгаа хүүхдийн тоог хэлнэ.



Зураг 4.12 Бүлэг дүүргэлтийн дундаж, аймаг, нийслэл, дүүргээр, 2024-2025



Зураг 4.13 Бүлэг дүүргэлтийн дундаж норматив хэмжээнээс хэтэрсэн сургуулийн тоо, 2024-2025



Зураг 4.14 Нэг ангид 45 ба түүнээс дээш бүлэг дүүргэлттэй ерөнхий боловсролын сургууль



4.3 ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРАЛЦАГЧИД

Хүснэгт 4.5 Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчид

Хичээлийн жил	Нийт	Өдөр	Орой	Эчнээ	Дүйцсэн
2024-2025	802,327	797,905			4,422
2023-2024	776,817	771,722			5,095
2022-2023	751,513	746,405	33	94	4,981
2021-2022	717,451	712,353	33	102	4,963

Тайлбар: *Нөхөн олгох хөтөлбөрөөр хичээллэж буй суралцагчийн тоо

4. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ

Хүснэгт 4.6 Ерөнхий боловсролын сургуульд суралцагчид, боловсролын түвшин, өмчийн хэлбэрээр



	2021/2022	2022/2023	2023-2024	2024-2025
Нийт суралцагчид	712,353	746,405	771,722	797,905
Төрийн	658,634	683,708	701,065	721,758
Хувийн	53,179	62,697	70,657	76,147
Бага	371,480	382,002	381,481	379,647
Дунд	238,348	251,347	262,266	273,943
Ахлах	102,525	113,056	127,975	144,315

Зураг 4.15 Сум болон багийн ерөнхий боловсролын сургуулийн суралцагчид



Хүснэгт 4.7 Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчид, байршил, өмчийн хэлбэрээр 2024-2025

Байршил	Улсын хэмжээнд, өмчийн бүх хэлбэрээр				Төрийн өмчийн			
	Нийт суралцагчид	Бага анги	Дунд анги	Ахлах анги	Нийт суралцагчид	Бага анги	дунд анги	Ахлах анги
Баг	4,281	2,251	1,360	670	4,281	2,251	1,360	670
Сум	185,013	89,270	65,902	29,841	184,588	89,110	65,750	29,728
Аймаг	211,273	98,425	71,015	41,833	201,149	95,000	67,252	38,897
Нийслэл	397,338	189,701	135,666	71,971	331,740	156,928	115,458	59,354
Нийт	797,905	379,647	273,943	144,315	721,758	343,289	249,820	128,649

Төрийн өмчийн сургуульд суралцаж буй нийт **721.7** мянган суралцагчийн **0.6** хувь нь багийн сургуульд, **25.6** хувь нь сумын сургуульд, **27.9** хувь нь аймгийн төвийн сургуульд, **46.0** хувь нь нийслэлд суралцаж байна.



Зураг 4.16 Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчид, хичээллэж буй ээлжээр, дүнд эзлэх хувиар, 2024-2025



Зураг 4.17 Ерөнхий боловсролын сургуулийн нийт суралцагчдын дүнд зарим онцлох ангиллын эзлэх хувь, 2024-2025



Хүснэгт 4.8 Ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын нийгмийн байдал, харьяалал, аймаг, дүүргээр, 2024-2025


Аймаг	НИЙТ	Малчдын хүүхэд	Гадаадын харьяат	Бүтэн өнчин	Хагас өнчин	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд
Улсын хэмжээнд	797,905	136,730	844	1,378	23,614	6,273
Аймаг						
БҮГД	399,177	125,706	104	666	11,342	3,018
Баян-Өлгий	26,989	8,617	50	62	684	197
Говь-Алтай	11,827	5,315	-	23	371	88
Завхан	15,683	6,110	-	23	427	94
Увс	19,984	7,948	1	28	554	149
Ховд	21,752	7,622	-	28	679	143
Архангай	19,761	10,579	-	19	460	127
Баянхонгор	19,542	8,710	3	28	615	118
Булган	11,457	5,045	-	15	316	76
Орхон	26,940	2,181	4	42	621	206
Өвөрхангай	25,090	9,893	-	50	701	230
Хөвсгөл	31,267	12,798	3	56	777	309
Говьсүмбэр	4,517	888	2	12	132	49
Дархан-Уул	27,205	2,115	13	46	687	275
Дорноговь	16,157	3,133	2	23	583	100
Дундговь	8,984	4,091	-	10	315	88
Өмнөговь	17,373	3,503	-	20	503	169
Сэлэнгэ	22,534	3,354	13	48	637	140
Төв	19,842	6,456	2	33	594	78
Дорнод	20,259	4,627	10	35	685	159
Сүхбаатар	14,466	6,383	1	22	497	111
Хэнтий	17,548	6,338	-	43	504	112
Дүүрэг						
Улаанбаатар	397,338	11,023	734	712	12,241	3,255
Багануур	7,283	968	3	15	227	69
Багахангай	865	95	-	1	40	7
Баянгол	62,045	1,178	34	73	1,579	510
Баянзүрх	101,295	2,506	309	211	3,087	830
Налайх	9,385	580	4	41	458	45
Сонгинохайрхан	68,089	2,784	18	154	2,515	364
Сүхбаатар	49,580	760	172	66	1,245	710
Чингэлтэй	29,432	647	7	56	1,187	136
Хан-Уул	69,364	1,505	187	95	1,903	584
Бусад	1,390	1	6	-	31	-

БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ГҮЙЦЭТГЭЛД СУУРИЛСАН ТӨСВИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ХҮРЭЭНД:


Боловсролын хууль тогтоомжийн шинэчлэл, цахим боловсрол, хүн бүрд чанартай боловсрол эзэмшүүлэх тэгш боломжийг бүрдүүлэх санхүүжилтийн хүрээнд бид ерөнхий боловсрол эзэмших Хувьсах зардлын бүтэц, бүрэлдэхүүнийг 1-12 дугаар анги бүрээр тооцон шинэчилж, математик, англи хэл, мэдээллийн технологийн хөтөлбөрүүдийг олон улсын жишигт нийцүүлж сайжруулах, цахим сургалтын орчныг бүрдүүлэх, шаардлагатай дэд бүтэц, үйлчилгээг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх, мэргэжлийн болон техникийн боловсрол мэргэжлийн өртөгт суурилсан хувьсах зардлын шинэчлэл, хэрэгжилтийг эхлүүллээ.



Зураг 4.18 Ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо



Зураг 4.19 Ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, бэрхшээлийн төрлөөр, 2024-2025




Шинэчлэн батлагдсан Боловсролын ерөнхий хуульд зарим онцлог шинэчлэл, өөрчлөлтүүдийг тусгасны нэг нь **“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучууд бусад үе тэнгийнхэнтэй хамтдаа суралцах тэгш боломжийг бүрдүүлэх”** чиглэлээр шинэ заалтыг тусгалаа.

Тухайлбал, сонсголын бэрхшээлтэй хүүхэд залуучуудын сургалтын хэл дохионы хэл байх, тохирох орчин, сурах бичгээр хангахтай холбоотой зохицуулалт өмнөх хуульд байхгүй байсныг харгалзан зарим шинэ заалтуудыг нэмж батлуулсан.



4.4 НЭГДҮГЭЭР АНГИД ЭЛСЭГЧИД

Зураг 4.20 Нэгдүгээр ангид шинээр элссэн суралцагчид, өмчийн хэлбэрээр




Зураг 4.21 Нэгдүгээр ангид элсэгчдийн дотор сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хүүхдийн эзлэх хувь



Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.2 -т "5 настай хүүхэд бүрийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангах"-аар тусгасан ба 2024-2025 оны хичээлийн жилд нэгдүгээр ангид элсэгчдийн дотор сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хүүхдийн эзлэх жин **98.0** хувьд хүрч, өмнөх хичээлийн жилээс **1.2** пунктээр өссөн байна.



Зураг 4.22 Нэгдүгээр ангид элсэгчдийн дотор сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хүүхдийн эзлэх хувь, аймгаар, 2024-2025




Зураг 4.23 Нэгдүгээр ангид элсэгчдийн элсэлтийн цэвэр жин



"Цэвэр жин" гэдэг нь тухайн шатанд хамрагдвал зохих насны хүүхдийн хэдэн хувь нь хамрагдсаныг илэрхийлнэ.

Нэгдүгээр элсэгчдийн элсэлтийн цэвэр жин 2024-2025 оны хичээлийн жилд 96.2 хувь болж өмнөх хичээлийн жилээс 2.9 пунктээр өссөн байна.

Зураг 4.24 Нэгдүгээр ангид элсэгчдийн элсэлтийн цэвэр жин, аймаг, дүүргээр, 2024-2025




Дүүргээр:	Чингэлтэй 84.8	Багахангай 77.0	Сонгино хайрхан 85.3	Налайх 101.2
	Баянгол 96.7	Багануур 106.6	Баянзүрх 90.8	Хан-Уул 109.5
				Сүхбаатар 128.8

Тайлбар: 2023-2024 оны хичээлийн жилийн хамран сургалтын цэвэр жинг тооцохдоо ҮСХ-ны 2022 оны жилийн эцсийн суурин хүн амын тоог нас дэвшүүлэн тооцсон.

4.5

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ХАМРАН СУРГАЛТ

Зураг 4.25 Хамран сургалтын цэвэр жин, ангиар




Тайлбар: Хүн амын тоо /2022 оны жилийн эцсийн суурин хүн амын тоог 2023 онд нас дэвшүүлэн тооцсон урьдчилсан гүйцэтгэл/.

2024-2025 оны хичээлийн жилд бага боловсролын (1-5-р анги) хамран сургалтын цэвэр жин **97.7** хувь байгаа бол дунд ангийн (6-9-р ангийн) хамран сургалтын цэвэр жин **96.0** хувь байна.



Зураг 4.26 Бага болон дунд боловсролын хамран сургалтын цэвэр жин, аймаг, дүүргээр, 2024-2025



Сүхбаатар, Хан-Уул, Багануур дүүрэгт боловсролын аль ч түвшинд хамран сургалт **100** хувиас илүү байгаа нь хамран сургах тойргийн бус суралцагч хамрагдсаныг илэрхийлж байна.

4.6 ЭЭЛЖИЙН КОЭФФИЦИЕНТ

Боловсрол, шинжлэх ухааны сайд, Нийгмийн хамгаалал, Хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2007 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 307/91/237 тоот тушаалаар анги дүүргэлтийг бага ангид **30-35** хүүхэдтэй, дунд, ахлах ангид **32-35** хүүхэдтэй байх нормативыг баталсан.




Хүснэгт 4.9 Төрийн өмчийн ЕБС-ийн ээлжийн коэффициент ба бүлэг дүүргэлтийн харьцуулалт, 2024-2025

Ээлжийн коэффициент	Бүлэг дүүргэлтийн дундаж ба сургуулийн тоо				Нийт сургуулийн тоо
	30 хүртэлх хүүхэдтэй	30-40 хүртэлх	40-50 хүртэлх	50+	
0-0.5 хүртэлх	41				41
0.5-1 хүртэлх	170	5			175
1-1.5 хүртэлх	183	38	3		224
1.5-2 хүртэлх	59	62	5		126
2+	27	84	27	1	139
Бүгд	480	189	35	1	705

Бага, дунд боловсролын хүртээмжтэй холбоотой тулгамдсан асуудлын нэг нь 2030 он хүртэлх бага, дунд боловсрол эзэмших хүүхдийн тооны өсөлт юм. Хүн ам зүйн энэхүү өөрчлөлт нь бүлэг дүүргэлт, ээлжийн коэффициентыг улам нэмэгдүүлэхээр байгаа ба цаашлаад сургалтын чанарт ч нөлөөлөх талтай юм.*

Иймд Боловсролын яамнаас Боловсролын чанарын ялгааг арилгах чиглэлээр суралцагчийн тооноос шалтгаалан ээлжийн коэффициент өндөр байгаа ерөнхий боловсролын сургуулийн бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх замаар ачааллыг бууруулах, нэг багшид ногдох суралцагчийн тоог багасгах, суралцагч хичээлээс гадуур сургуулийн орчинд хөгжих, дугуйлан, бусад хөтөлбөрт хамрагдах боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

* Эх үүсвэр: Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө, 2021-2030 он.



Хүснэгт 4.10 Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын анги дэвшилтийн хувь, 2024-2025

I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
99.4	99.4	99.6	99.7	99.6	99.5	99.0	99.6	99.6	83.6	98.4	99.5

4.7

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ДОТУУР БАЙР

Зураг 4.27 Дотуур байртай сургуулийн тоо, дотуур байрны тоо, 2024-2025



Зураг 4.28 Дотуур байрны хүчин чадал, түүнд амьдарч буй хүүхдийн тоо, 2024-2025




Зураг 4.29 Дотуур байрны тоо, тэдгээрийн барилгын стандарт хангалт, 2024-2025




Хүснэгт 4.11 Дотуур байрны хангалтын хувь

	Суралцагчид			Малчдын хүүхэд			Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд
	Хүсэлт гаргасан	Амьдарч буй	Дотуур байрны хангалт	Хүсэлт гаргасан	Амьдарч буй	Дотуур байрны хангалт	
2024-2025	35,817	35,486	99.1	27,359	27,136	99.2	283
2023-2024	37,062	36,029	97.0	28,845	28,122	97.0	323
2022/2023	35,616	35,077	98.0	27,240	26,870	99.0	376
2021/2022	34,546	32,576	94.0	26,458	25,169	95.0	430

Зураг 4.30 Дотуур байранд амьдарч буй суралцагчид, ангиар, 2024-2025



Зураг 4.31 Дотуур байранд ажиллаж байгаа нийт багш, ажиллагчдын тоо




4.8

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙГ ТӨГСӨГЧИД

Зураг 4.32 Ерөнхий боловсролын сургуульд суралцаж суурь, бүрэн дунд боловсрол эзэмшсэн төгсөгчид




Зураг 4.33 Ерөнхий боловсролын сургуулийг төгсөгчид, боловсролын түвшнээр, 2023/2024



2023-2024 оны хичээлийн жилд ЕБС-ийг нийт **101.0** мянган хүүхэд (9-р ангийг **64.4** мянга, 12-р ангийг **35.6** мянга) өдрөөр суралцан төгссөн нь өмнөх оны хичээлийн жилээс **8.2 (8.9 хувь)** мянгаар өссөн байна.

Зураг 4.34 Ерөнхий боловсролын сургуулийн 9 болон 12 дугаар ангийг өдрөөр суралцан төгсөгчид, аймгаар, 2023/2024




Тайлбар: Бусад гэдэгт БНСУ дахь Монгол сургууль, Кембрижийн хөтөлбөрөөр хичээллэж байгаа сургуулиудыг хамруулав.



Улсын хэмжээнд 2023-2024 оны хичээлийн жилд бага анги төгсөгчдийн бохир жин **99.1** болж өмнөх жилээс **1.0** пунктээр өссөн байна.

Зураг 4.35 Бага анги төгсөлтийн (өдөр) бохир жин, аймгаар, 2023/2024 оны хичээлийн жилд



4.9

ЭЛСЭЛТИЙН ЕРӨНХИЙ ШАЛГАЛТ

ЭЛСЭЛТИЙН ЕРӨНХИЙ ШАЛГАЛТЫГ ЖИЛД ХОЁР УДАА ЗОХИОН БАЙГУУЛДАГ ТОГТОЛЦООНД ШИЛЖЛЭЭ.

Боловсролын сайдын 2022 оны А/47 тоот тушаалд “Оюутан элсүүлэх журам”-ын дагуу элсэлтийн ерөнхий шалгалтыг жилд хоёр удаа зохион байгуулах нэмэлт өөрчлөлтийг тусгасан.

Энэ нь шалгуулагч өмнөх шалгалтын дүн оноогоо ахиулах боломжийг дэмжиж байгаагаараа онцлогтой.

2023 онд аймгуудын Засаг дарга нартай байгуулсан гэрээнд туссан онцлог ажлын нэг нь “Сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжил, хамгаалал болон сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдаас авах улсын шалгалт, чанар болон гүйцэтгэлийн үнэлгээ, ерөнхий боловсролын сургууль төгсөгч, их, дээд сургууль, коллежид элсэгчдээс авах монгол хэл, бичиг, элсэлтийн ерөнхий шалгалтыг чанартай зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх” тухай заалтыг тусгасан байна.

Зураг 4.36 Элсэлтийн ерөнхий шалгалтад хамрагдсан иргэний тоо, 2024 он



Нийт шалгуулагчид **33,369**

2024 оны шалгуулагч **29,582**

Өмнөх оны шалгуулагч **3,787**



Эх үүсвэр: Боловсролын үнэлгээний төвийн статистикийн тайлангийн систем, 2024 он
Тайлбар: Маягтын дагуу 2024 оны 7-р сард авсан элсэлтийн шалгалт өгсөн шалгуулагчдын тоог илгээж байна.

Хүснэгт 4.12 Элсэлтийн ерөнхий шалгалтын статистикийн мэдээлэл, сургуулийн байршлаар, 2024 он

Шалгалтын нэр	Улаанбаатар			Аймгийн төв		
	Ш.Тоо	А.О.Д	Х.О.Д	Ш.Тоо	А.О.Д	Х.О.Д
Математик	10,470	25	503	6329	26.8	518.5
Монгол хэл	5,054	37	491	2638	42.1	531.9
Нийгмийн ухаан	9,225	43	498	4705	49.6	531.3
Англи хэл	11,182	39	514	5228	35.8	503.8
Орос хэл	252	70	600	97	70.6	600.8
Газар зүй	461	44	505	155	51.3	551.1
Физик	3,827	34	497	2251	39.5	528.7
Биологи	2,127	48	511	1729	50.8	524.7
Хими	2,143	27	514	1741	27.7	520.8
Монгол улсын түүх	724	39	494	154	53.5	562.6

Шалгалтын нэр	Сумын төв		
	Ш.Тоо	А.О.Д	Х.О.Д
Математик	4,160	23	493
Монгол хэл	2,666	40	516
Нийгмийн ухаан	3,790	44	500
Англи хэл	3,214	29	470
Орос хэл	70	47	439
Газар зүй	189	43	500
Физик	1,606	33	497
Биологи	1,347	44	486
Хими	1,339	22	482
Монгол улсын түүх	158	50	547

Хүснэгт 4.13 Элсэлтийн ерөнхий шалгалтын статистикийн мэдээлэл, сургуулийн өмчийн хэлбэрээр, 2024 он

Шалгалтын нэр	Төрийн өмчит сургууль (1779)			Хувийн өмчит сургууль (632)		
	Ш.Тоо	А.О.Д	Х.О.Д	Ш.Тоо	А.О.Д	Х.О.Д
Математик	19107	24.3	500.7	1852	32.3	555.7
Монгол хэл	9906	39.2	506.6	452	42.7	535.5
Нийгмийн ухаан	16556	44.7	505.7	1164	49.8	534.5
Англи хэл	17650	34.4	495.0	1974	53.3	584.7
Орос хэл	337	63.3	550.3	82	80.3	669.0
Газар зүй	718	44.3	505.8	87	54.2	568.8
Физик	6869	34.0	499.9	815	46.4	560.3
Биологи	4858	47.2	505.7	345	56.2	553.8
Хими	4841	25.6	504.1	382	33.0	555.9
Монгол улсын түүх	925	42.3	507.4	111	50.2	553.4

Хүснэгт 4.14 Элсэлтийн ерөнхий шалгалтын статистикийн мэдээлэл, хүйсээр, 2024 он

Шалгалтын нэр	Эрэгтэй			Эмэгтэй		
	Ш.Тоо	А.О.Д	Х.О.Д	Ш.Тоо	А.О.Д	Х.О.Д
Математик	11274	24.4	499.2	11728	24.3	501.3
Монгол хэл	3935	33.8	459.9	7853	40.7	520.1
Нийгмийн ухаан	8233	38.0	468.4	11755	47.7	522.4
Англи хэл	9661	35.7	498.9	11793	35.7	501.3
Орос хэл	138	65.0	562.1	359	63.7	553.1
Газар зүй	548	44.6	507.1	457	42.3	491.4
Физик	5874	33.3	495.4	2483	36.5	511.4
Биологи	1349	43.0	481.4	4493	47.3	505.6
Хими	1448	23.7	486.8	4454	25.7	504.3
Монгол улсын түүх	561	41.8	503.8	778	40.6	497.6

Эх үүсвэр: Боловсролын үнэлгээний төвийн статистикийн тайлангийн систем, 2024 он

Тайлбар: 2022 оноос өмнө төгсөгчдийн мэдээлэл хасагдсан болно.

Ш.Тоо - Шалгуулагчийн тоо, А.О.Д - Анхны онооны дундаж, Х.О.Д - Хэмжээст онооны дундаж


4. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ

Хүснэгт 4.15 Элсэлтийн ерөнхий шалгалтад 800 оноо авсан шалгуулагчид, шалгалтын төрлөөр, 2024 он


ШАЛГАЛТЫН НЭР	Нийт шалгуулагчийн тоо	800 оноо авсан шалгуулагчийн тоо	Дүнд эзлэх хувь
Математик	23002	31	0.13
Монгол хэл	11788	17	0.14
Нийгмийн ухаан	19988	31	0.16
Англи хэл	21454	35	0.16
Орос хэл	497	13	2.62
Газар зүй	1005	2	0.20
Физик	8357	15	0.18
Биологи	5842	7	0.12
Хими	5902	8	0.14
Монгол улсын түүх	1339	1	0.07

4.10 ҮНДСЭН БАГШ БОЛОН АЖИЛЛАГЧИД


Зураг 4.37 Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажиллагчид, өмчийн хэлбэрээр



Зураг 4.38 Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багш, өмчийн хэлбэрээр



Зураг 4.39 Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багш, ангиллаар



Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажил мэргэжлийн стандартыг боловсруулах ажлын хэсэг (Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/364 дүгээр тушаал)-ээс боловсруулсан стандартын төслийг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлж, зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 3-ны өдрийн 3 дугаар тогтоолоор батлагдлаа.

Ерөнхий боловсролын сургуулийн бага боловсролын багшийн ажил мэргэжлийн стандарт 2341-01 индексээр, бүрэн дунд боловсролын багш 2330 индексээр бүртгэгдсэн. Багшийн ажил мэргэжлийн стандарт батлагдсанаар багшийн албан тушаалын тодорхойлолт шинэчлэх, багш бэлтгэдэг их, дээд сургуулийн хөтөлбөрийг шинэчлэх, багшийн ажлын норм, нормативыг шинэчлэн тогтоох суурь болох юм.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын чуулганаар Боловсролын багц хуулийг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр шинэчлэн баталж, 8 сарын 3-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлж эхэлсэн. Хууль шинэчлэгдсэнээр гарсан гол өөрчлөлт, шинэчлэлийн нэг нь Багшийн хөгжлийн асуудал байсан. Тодруулбал, Монгол Улсад багш бэлтгэх тогтолцоог шинэчилж, багш мэргэжилтнүүдийг бэлтгэх их дээд сургуулиудад магадлан итгэмжлэгдсэн байх шаардлагыг тавьсан. Мөн ажлын байран дээр багшийн мэргэжлийн тасралтгүй суралцах, хөгжих боломжийг олгосон явдал юм.

Боловсролын багц хуулийн шинэчлэлийг Монгол Улс анх удаа хийсэнтэй холбогдуулан Монгол Улсын засгийн газраас Боловсролын салбарын реформыг хэрэгжүүлэхдээ багш бэлтгэх сургалтад онцгойлон анхаарч байна. Тодруулбал, багш мэргэжлээр суралцах оюутны сургалтын төлбөрийг энэ хичээлийн жилээс 2030 он хүртэл төр 100 хувь, багш нар дотооддоо магистрт суралцах бол сургалтын төлбөрийг төр 100 хувь хариуцахаар болсны зэрэгцээ МУБИС-ийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хөтөлбөрийг шинэчлэх, элсэгчдийн босго оноог өндөрсгөх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Багш бэлтгэх тогтолцоог шинэчилж, багшийн хөгжлийг 2030 он хүртэл бодитой дэмжсэнээр олон улсад өрсөлдөхүйц, эх хэлний болон англи хэлний ур чадвартай олон мянган чадварлаг багшийг бэлтгэх юм.


БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ГҮЙЦЭТГЭЛД СУУРИЛСАН ТӨСВИЙН ШИНЭЧЛЭЛ

Багшийн нийгмийн хамгааллыг сайжруулах, ажлын ачааллыг гүйцэтгэлд тооцох, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангахын тулд хувьсах зардлын бүрэлдэхүүнд ангийн хүүхдийн тооноос хамаарсан нэмэгдлийг шинээр тусгаж, багшийн хөгжлийн зардлыг багш бүрээр тооцон олгодог болсон.

Хувьсах зардлын бүрэлдэхүүнд эрүүл мэндийн эрт илрүүлгийн шинжилгээний багцад ороогүй, багшийн ажлын онцлогоос хамаарсан эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйлчилгээний зардлыг баталснаар багш нар шинжилгээндээ хамрагдаад байна.




Зураг 4.40 Ерөнхий боловсролын сургуулийн мэргэжлийн багшийн хангалтын хувь




Мэргэжлийн багшийн хангалт 2023-2024 оны хичээлийн жилд 97.1 хувь болж өмнөх оны хичээлийн жилээс 1.3 пунктээр буурсан байна.

Зураг 4.41 Мэргэжлийн багшийн хангалтын хувь, аймгаар, 2024-2025





Зураг 4.42 Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багшийн насны бүлэг, хүйс, 2024-2025



БАГШИЙН МЭРГЭЖЛИЙН ХӨГЖИЛ, АЖЛЫН АЧААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 10 дугаар сарын 26-ний өдрийн А/430 дугаар тушаалаар "Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлыг үнэлэх, дүгнэх журмыг" баталсан.
- Багшийн хөгжилд багш бэлтгэх их, дээд сургууль, ахмад багш нар багшийн мэргэжлийн хөгжлийг сургуульд суурилан зохион байгуулж байна.
- Багш нар мэргэжлийн хөгжлийн зардлаа хэрэгцээндээ нийцүүлэн өөрөө зарцуулдаг, сонгож суралцдаг боллоо.
- Багш үндсэн сургалтаас гадна өөрийн хэрэгцээнд нийцүүлэн модуль сургалтад хамрагдах, ажлын байрандаа мэдлэг, туршлагатай багшаас суралцах, өөрийн туршлагаа түгээн дэлгэрүүлэх боломжоор хангагдаж байна.
- Багшийн ажлын ачааллыг бууруулах, нормыг шинэчлэх хүрээнд багшийн ажил мэргэжлийн стандарт боловсруулж, ажил үүргийн шинжилгээ, ачааллын судалгааг хийлээ.
- Монгол Улсын Засгийн газраас багш бэлтгэх, багшийн тасралтгүй хөгжил, нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд багш бүрийг компьютержуулах арга хэмжээг 2024 оноос үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.


Зураг 4.43 Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багшийн тоо, насны бүлгээр, 2024-2025**Зураг 4.44 Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багшийн тоо, ажилласан жилээр, 2024-2025**

Боловсролын салбарын гүйцэтгэлд суурилсан төсвийн шинэчлэл - Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын гүйцэтгэл, үр дүнд суурилсан урамшууллыг олгож эхлээд байна.


Багш нарын цалингийн зэрэглэл, шатлалд өөрчлөлт оруулаа./ Засгийн газрын 2022 оны 107 тоот тогтоол батлагдсан/

- Багшийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээс хамаарч 40% хүртэл урамшууллыг сар бүр авах боломжийг бүрдүүлээ.


Зураг 4.45 Нэг багшид ногдох хүүхдийн тооны улсын дундаж, байршлаар, 2024-2025



Зураг 4.46 Ерөнхий боловсролын сургуулийн нэг багшид ногдох хүүхдийн тооны дундаж



Зураг 4.47 Ерөнхий боловсролын сургуулийн нэг багшид ногдох хүүхдийн тооны дундаж, аймгаар, 2024-2025



4.11

СУРГУУЛИЙН СЭТГЭЛ ЗҮЙЧ

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А/222 дугаар тушаалаар ерөнхий боловсролын сургуульд **“СУРГУУЛИЙН СЭТГЭЛ ЗҮЙЧ”**-ийг ажиллуулж эхэлсэн.


2024-2025 оны хичээлийн жилд улсын хэмжээнд **421 сэтгэл зүйч** ерөнхий боловсролын сургуульд ажиллаж байна.



Хүснэгт 4.16 Сургуулийн сэтгэл зүйч, аймгаар

Аймаг	2022-2023 оны хичээлийн жил			2023-2024 оны хичээлийн жил			2024-2025 оны хичээлийн жил		
	Сэтгэл зүйчтэй сургууль	Аймгийн төв	Сум	Сэтгэл зүйчтэй сургууль	Аймгийн төв	Сум	Сэтгэл зүйчтэй сургууль	Аймгийн төв	Сум
Архангай	2	1	1	4	2	2	4	2	2
Баян-Өлгий	1	1		0			15	7	8
Баянхонгор	4	2	2	4	2	2	12	6	6
Булган	1	1		3	1	2	5	3	2
Говь-Алтай	4	2	2	1		1	11	5	6
Говьсүмбэр	1	1		3	2	1	5	3	2
Дархан-Уул	4	3	1	5	2	3	12	11	1
Дорноговь	2	1	1	3	2	1	7	3	4
Дорнод	2	2		4	3	1	7	6	1
Дундговь	0			3	2	1	4	3	1
Завхан	1	1		3	2	1	3	2	1
Орхон	10	8	2	6	4	2	15	15	
Өвөрхангай	7	4	3	4	2	2	12	5	7
Өмнөговь	3	2	1	4	3	1	8	3	5
Сүхбаатар	6	4	2	4	2	2	7	3	4
Сэлэнгэ	2	1	1	5	2	3	15	4	11
Төв	2	1	1	1	1		5	2	3
Увс	1	1		1	1		5	4	1
Ховд	0			3	2	1	17	7	10
Хөвсгөл	6	4	2	4	2	2	19	7	12
Хэнтий	3	1	2	3	2	1	8	4	4
Нийт	62	41	21	68	39	29	196	105	91

Зураг 4.48 Сургуулийн сэтгэл зүйч, байршлаар



Хүснэгт 4.17 Сургуулийн сэтгэл зүйч, дүүргээр

Нийслэл	2022-2023 оны хичээлийн жил	2023-2024 оны хичээлийн жил	2024-2025 оны хичээлийн жил
Багануур	2	2	4
Багахангай	1	1	1
Баянгол	14	12	32
Баянзүрх	13	16	54
Налайх		1	3
Сонгинохайрхан	8	11	26
Сүхбаатар	9	12	36
Чингэлтэй	10	10	16
Хан-Уул	9	15	53
Нийт	66	80	225

Зураг 4.49 Сургуулийн сэтгэл зүйчийн үйл ажиллагааны үр дүн...



Хүснэгт 4.18 Сургуулийн сэтгэл зүйчийн үйл ажиллагааны үр дүн

2024-2025 оны хичээлийн жил	Сурагч	Эцэг эх, асран хамгаалагч	Багш, сургуулийн ажилтан	Нийт
Сэтгэл зүйн зөвлөгөө	9,650	2,658	2,307	14,615
Сэтгэл зүйн булгийн зөвлөгөө	24,932	1,506	4,530	30,968
Сэтгэл зүйн сургалт	185,604	41,215	21,005	247,824
Сэтгэл зүйн оношилгоо	67,200	9,306	8,857	85,363
Нийт	287,386	54,685	36,699	378,770

Хүснэгт 4.19 Сэтгэл судлал мэргэжлээр суралцаж байгаа оюутны мэдээлэл


Сургууль	1-р дамжаа	2-р дамжаа	3-р дамжаа	4-р дамжаа	Нийт
Дархан дээд сургууль	23	16	26	4	69
ДХИС /Дотоод хэргийн их сургууль/		1		9	10
ИЗОУИС /Их засаг олон улсын их сургууль/	61	55	64	44	224
МУБИС /Монгол улсын боловсролын их сургууль/	276	366	237	243	1,122
МУИС /Монгол улсын их сургууль/	158	96	126	158	538
МҮИС /Монголын үндэсний их сургууль/	7		7	7	21
Нийгэм, сэтгэл судлалын дээд сургууль	261	86	15	7	369
Олон улсын Улаанбаатарын их сургууль	60	32	36	34	162
Орхон их сургууль	1				1
Отгонтэнгэр их сургууль	145	9	41	1	196
Санхүү, эдийн засгийн их сургууль	8		9		17
Сити их сургууль	8	7	11		26
Улаанбаатар эрдэм их сургууль	137	3	8	7	155
ХУИС /Хүмүүнлэгийн ухааны их сургууль/	87	121	108	116	432
ШУТИС /Шинжлэх ухаан технологийн их сургууль/	36	38	19	26	119
Эм Ай Ю дээд сургууль	9				9
Нийт	1,277	830	707	656	3,470



4.12 ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ҮДИЙН ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

2023-2024 оны хичээлийн жилд "Ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих шаардлага" MNS7005:2023 стандартыг баталж, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлийн орчин нөхцөл, хоолны чанар, аюулгүй байдлыг хангах боломж бүрдлээ.

Зураг 4.50 Үдийн хоолны үйлчилгээнд хамрагдаж буй 1-5 дугаар ангийн нийт суралцагчийн тоо




2024-2025 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн **I-V ангийн нийт 379,647 суралцагч** үдийн хоолны үйлчилгээнд хамрагдаж байна.

2024-2025 оны хичээлийн жилд ЕБС-ийн үдийн хоолны газрын хоол үйлдвэрлэлийн захиргааны статистикийн тайлангаар төрийн өмчийн нийт **705 сургуулийн 585 (83.0%)** нь хоолны газраа өөрсдөө ажиллуулдаг, **120 (17.0%)** нь хоолны газраа түрээслэн үйл ажиллагаа явуулдаг байна.



Зураг 4.51 Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд ажиллаж буй ажилтны тоо




Тайлбар: 2024-2025 оны хичээлийн жилийн тогоочийн тоонд дотуур байрны тогоочийн тоог оруулж тоолсон.

Зураг 4.52 Монгол улсын хүн амын хоол тэжээлийн байдал

Эрүүл мэндийн яамнаас 2017 онд хийсэн судалгааны дүн



Зураг 4.53 ЕБС-ийн сурагчдын хоол тэжээлээс хамааралтай эмгэгийн тархалтын түвшин



Хүн амын хоол тэжээлийн байдал үндэсний-VI р судалгааны тайлан, 2024 он



Хүснэгт 4.20 Өсвөр үеийнхний шингэний хэрэглээ

	Дундаж, мл (Асуумж)	24 цагийн хооллолтын асуумж		
		Дундаж	Ажлын өдөр, мл	Амралтын өдөр, мл
Эрэгтэй	1,015.1	1,031.7	1,000.7	1,201.6
Эмэгтэй	968.7	1,000.8	940.5	1162
Дундаж	992.1	1016	970	1,181.9


Хүснэгт 4.21 Өсвөр үеийнхний шингэний хэрэглээ, кг/жин

	Дундаж кг/мл	ИХ 95, кг/мл
Эрэгтэй	29.5	27.7-31.2
Эмэгтэй	30.0	27.8-32.2

4.13

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ХООЛ ЗҮЙЧ


Зураг 4.54 Хоол зүйчтэй сургууль



“Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай” хууль 2019 онд батлагдаж 2020 оноос эхлэн ерөнхий боловсролын сургууль халуун хоолоор үйлчилж эхэлсэн.


Тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь заалтад “Сургуулийн хоол зүйч сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг удирдан зохион байгуулж, суралцагч, ажилтан, эцэг эхэд мэргэжлийн зөвлөгөө өгнө.” гэж тусгасан.

Зураг 4.55 Хоол зүйчийн тоо



“Ерөнхий боловсролын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль”-д сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг удирдан зохион байгуулах хоол зүйч нь дараах эрх, үүрэгтэй:

1. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд зохистой дадал нэвтрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих;
2. Хоолны цэс боловсруулж, сургуулийн захирлаар батлуулах;
3. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд оролцогчдод мэргэжил, арга зүйн зөвлөгөөг өгөх;
4. Сургуулийн хоол үйлдвэрлэлийн хүнсний хангамжийн талаар сургуулийн захиргаанд захиалга, хүсэлт, шаардлага гаргах;
5. Суралцагчид хооллох зөв дадал, хооллох соёл; тэнцвэртэй хооллолт, шимт бодисын тухай суурь ойлголтыг эзэмшүүлэх;
6. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хянах;
7. Давтан сургалтад хамрагдах.



4.14 ЦАХИМЖСАН БОЛОВСРОЛ

БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ЦАХИМ ШИЛЖИЛТИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭЖ БУЙ ОНЦЛОГ АЖЛУУД:

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дугаар тогтоолоор 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдаж, боловсролын салбарын шинэчлэлийг тэргүүлэх чиглэлд тодорхойлсон. Энэхүү тэргүүлэх чиглэлийн нэг нь “Цахимжсан боловсрол” гэсэн зорилт юм.

Ковид-19 цар тахлын нөлөөгөөр боловсролын салбарт цахим шилжилт эрчимжсэн. Монгол Улсын Засгийн газар энэ чиглэлд онцгой анхаарал хандуулж, НҮБ-ын “Хувьсаж буй боловсрол” дээд хэмжээний чуулга уулзалтын хүрээнд “Дижитал суралцахуй ба хувирган өөрчлөлт” сэдвээр тусгайлсан хэлэлцүүлэг зохион байгуулж, энэ чиглэлд хэрэгжүүлэх үүрэг, амлалтаа танилцуулсан билээ.

Боловсролын хууль тогтоомжид бид анх удаа цахим, зайны сургалт, цахим шилжилттэй асуудлыг хуульчилсан.

Үүнтэй зэрэгцэн хүмүүс XXI зууны боловсрол, түүнийг олгох, олж авах тухай асуудлыг шинэ өнцгөөр харах болсон юм. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд “Ерөнхий боловсролын сурах бичиг нь хэвлэмэл, цахим хэлбэртэй байна” гэж заасан. Та бүхэн мэдэж байгаа байх, 12 сарын 06-нд бага ангийн сурагчдын цүнхний жинг багасгаж, дасгал, даалгавруудыг илүү сонирхолтой, интерактив, бүтээлч болгох зорилгоор Боловсролын яам Польшийн “Learnetic” компанийн техникийн дэмжлэгтэйгээр I-V ангийн есөн төрлийн сурах бичгийг дижитал хэлбэрт шилжүүлснийг бид хүлээн авсан. Ингэснээр бага ангийн 33 сурах бичгийн агуулга, дасгал, даалгаврыг интерактив хэлбэрт хөрвүүлж, 13,500 орчим дасгал, даалгаврын сантай болсон.

2024-2025 оны хичээлийн жилээс эхлэн бид нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 4000 төгрөг, уртасгасан цагийн зохицуулалттай 24 цагийн цэцэрлэг, цэцэрлэгийн бүлгийн хүүхэд болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 5100 төгрөгөөр шинэчлэн тогтоосон.


Цэцэрлэгт хүүхдийн эрүүл мэнд, өсөлт, хөгжилтөд дэмжлэг болохуйц чанартай хоол идэхэд, идэж байгаа хоолных нь орц, найрлага, шим тэжээлийг нэмэгдүүлэхэд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хувь нэмрээ оруулах Засгийн газрын тогтоолыг батлуулан, хэрэгжилтэд цахим системийг ашиглаж байна.

Боловсрол сургалтын байгууллага систем хөгжүүлэгч хувь хүн, хуулийн этгээдийн хөгжүүлсэн мэдээллийн систем ашиглаж буй тохиолдолд Боловсролын салбарын мэдээллийн системтэй мэдээлэл солилцооны систем ашиглаж мэдээлэл солилцдог боллоо.

2025 онд дараах томоохон арга хэмжээг төлөвлөж байна.

- Боловсролын бодлого, санхүүжилт, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг их өгөгдөлд суурилсан дата аналитикийн системийг боловсролын бүх түвшинд хөгжүүлж, нэвтрүүлэх
- Иргэдийн насан туршдаа суралцахуйн удирдлага мэдээллийн системийг хөгжүүлэх
- Боловсролын үнэлгээг цахимжуулах

Зураг 4.56 Боловсролын салбарын мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдсон төрийн өмчийн сургуулийн хичээлийн байрны тоо, 2024/2025



Боловсролын салбарын мэдээллийн систем болон LMS/SMS

Өнгөрсөн хугацаанд боловсролын салбарын үйл ажиллагааг цахимжуулах, иргэдэд шуурхай үйлчлэх, салбарын мэдээллийг бодитой болгох зорилгоор “Боловсролын салбарын мэдээллийн систем”-ийг 2013 оноос боловсруулж, хэрэглээнд үе шаттай нэвтрүүлж, төрийн болон төрийн бус өмчийн, боловсролын бүх түвшний нийт сургалтын байгууллага үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус системийн үндсэн санд тулгуурлан боловсролын салбарын өгөгдлийн сангийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхээр өгөгдлийн сангийн шинжилгээний загвар платформыг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Зураг 4.57 Боловсролын салбарын мэдээллийн систем болон LMS/SMS



ESIS.EDU.MN Боловсролын салбарын дундын мэдээллийн систем

- Цэцэрлэг
- Ерөнхий боловсрол
- Насан туршийн боловсрол
- Боловсролын баримт бичиг
- QR кодоод суурилсан бүртгэл

TVETS.EDU.MN /Техникийн болон мэргэжлийн боловсрол/

- Техникийн боловсрол
- Мэргэжлийн боловсрол

HEMIS.EDU.MN /Дээд боловсролын удирдлагын систем/

- Дээд боловсролын баримт бичгийн блокчэйн технологиор баталгаажуулах
- Дээд боловсролын үйл ажиллагааг цахимжуулах

Хувийн хэвшлийн LMS/SMS системүүдийг цэцэрлэг, сургууль сонголттойгоор боловсрол, сургалтын үйл ажиллагаанд ашиглаж, ашиглалт, үйлчилгээний зардлыг хувьсах зардлын цахим хэрэглээний зардлаас санхүүжүүлдэг болсон. Жилийн эцсийн байдлаар 520 сургууль SMS, LMS-ийг, 11 сургууль хоолны системийг нэвтрүүлэн сургалтын үйл ажиллагаандаа ашиглаж байна. Мөн Боловсролын ерөнхий хуулийн 40.2.9 дэх заалт, МУЗГ-ын “Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2024 оны 73 дугаартай тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүүхдийн хоолны түүхий эдийн зардлыг эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс татан төвлөрүүлэх системд тавих техникийн шаардлага”-г ТНБД баталж тус шаардлагад нийцсэн 5 хоол үйлдвэрлэл, үйлчилгээний систем хөгжүүлэгч байгууллагыг БМТТ-ийн цахим хуудсанд нээлттэй байршуулсан. Үүнээс цэцэрлэгийн зөвлөл сонголт хийж, системийг ашиглаж, ашиглалт, үйлчилгээний зардлыг хувьсах зардлын цахим хэрэглээний зардлаас санхүүжүүлдэг болсон. 12-р сарын байдлаар нийслэлийн төрийн өмчийн 305 цэцэрлэг хоолны түүхий эдийн зардлыг хүүхдийн ирцэд тулгуурлан эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс татан төвлөрүүлж байна.

Дээрх боловсролын байгууллагад хэрэглэгдэж буй системүүдээс БСМС-руу бодит цагийн горимоор мэдээлэл солилцож байгаа бөгөөд 2024 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын Засгийн газрын 432-р журмын дагуу LMS/SMS, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний, номын сангийн, цахим гэрээний, дээд боловсролын байгууллагын удирдлагын болон шалгалтын зэрэг нийт 19 байгууллагатай Боловсролын яам “Мэдээлэл солилцох гэрээ” байгуулаад байна.

Дэд бүтэц болон тоног төхөөрөмжийн нөхөн хангалт

Боловсролын ерөнхий хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10. дахь хэсэг “39.10.1.төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг арилжааны хөнгөлөлттэй нөхцөлөөр лизинг болон түрээсийн гэрээгээр хоёр буюу түүнээс дээш жилийн хугацаатай эзэмших, ашиглах, худалдан авах зардал” гэж тусгагдсан.

Мөн дээрх хуулийн заалттай холбоотойгоор Улсын Их Хурлаас 2023 оны 11 дүгээр сарын 100 дугаар тогтоол батлагдсан. Энэхүү тогтоолын 1.1 дэх заалтад “боловсрол дахь тэгш бус байдлыг арилгах, боловсролын чанарыг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, боловсролын цахим шилжилтийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн анги танхимыг интернэт, дотоод сүлжээнд бүрэн холбох, багш бүрийг компьютержуулах, хүүхдийн авьяасыг дэмжих, цахим системд суурилсан нэмэлт хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчим болон холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн санхүүгийн түрээс хэлбэрээр зохион байгуулах” гэж заасан.

Боловсролын салбарын төсөв, санхүүжилтийн шинэчлэлийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2022 оны “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай” 91 дүгээр тогтоолоор батлагдсан ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн нэг суралцагчид нотлох хувьсах зардлын дундаж нормативын бүрэлдэхүүнд “Цахим хэрэглээний зардал”, “Тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардал”-ыг анх удаа тусгасан бөгөөд 2024 оны “Тогтоолын хавсралт шинэчлэн батлах тухай” 53 дугаар тогтоолоор хувь хэмжээ өөрчлөгдөн батлагдсан.

Боловсролын яамнаас 2024 онд багшид зөөврийн компьютер олгох үйл ажиллагааг зохион байгуулж, 2024 оны жилийн эцсийн байдлаар орон нутгийн хөрөнгө оруулалтаар 11,696, төсөл хөтөлбөрийн хүрээнд 250, хандив тусламжаар 1,000, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 4,043, нийт 16,989 ширхэг зөөврийн компьютер багш нарт олгосон байна. 2024-2025 оны статистикийн мэдээллээр төрийн өмчийн 705 сургуулийн 32,728 үндсэн багшийн 28,293 зөөврийн компьютертой, 2,955 багш зөөврийн компьютергүй байна.

Боловсролын яамнаас 2023 оноос утасгүй дотоод сүлжээний орчин бүрдүүлэх төсөл арга хэмжээг 24 сарын хугацаанд, цахим танхим байгуулах төсөл арга хэмжээг 48 сарын хугацаанд төлбөрийг хуваан төлөх нөхцөлтэй ерөнхий гэрээний журмаар зохион байгуулж байгаа бөгөөд 2024 оны жилийн эцсийн байдлаар 705 сургуулиас утасгүй дотоод сүлжээний орчин бүрдүүлэх ажил дээр 543 сургууль, цахим танхим байгуулах ажил дээр 262 захиалга

өгч гэрээ байгуулж, суурилуулалтын ажлыг гүйцэтгэж, хувьсах зардлыг тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлаас санхүүжүүлж байна.

Зураг 4.58 Дэд бүтэц болон тоног төхөөрөмжийн нөхөн хангалт



Цахим контентын сан бүрдүүлэх болон цахим сургалт

Боловсролын яамнаас 2019 оноос эхлэн ЕБС-ийн суралцагч бие даан суралцах, мэдлэг чадвараа бататгах үйлийг дэмжих, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн үед хичээл, сургалтын тасралтгүй байдлыг хангах, багш хичээл, сургалтыг зайнаас зохион байгуулах, дэлхийн өнцөг булан бүрд ажиллаж, амьдарч байгаа шилдэг багшийн бэлтгэсэн цахим хичээлийг суралцагч орон зай, цаг хугацаанаас үл хамааран насан туршдаа суралцах, цахим контентын нэгдсэн сан бүрдүүлэх зорилго бүхий MEDLE.MN сургалтын нэгдсэн платформыг боловсруулсан. Тус платформд тулгуурлан багш бүрийг цахим агуулга боловсруулах боломжоор хангаж, нийлүүлсэн контентын үр дүнгээр нэмэлт орлого олох боломжийг бүрдүүлсэн юм.

БШУ-ны сайдын 2022 оны "Журам батлах тухай" 123 дугаар тушаалаар ЕБС-ийн контентын санг бүрдүүлэх журам, 2022 оны "Аргачлал шинэчлэн батлах тухай" А/384 дугаар тушаалаар ЕБС-ийн хичээлийн контент сонгон шалгаруулах аргачлал тус тус батлагдсан бөгөөд журам, аргачлалын дагуу багш нарын дунд нээлттэй сонгон шалгаруулах ажил үргэлжлэн хийгдэж байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар MEDLE контентын санд ээлжит хичээл 10,979 үүнээс заавал судлах хичээлийн 9,414, сонгон судлах хичээлийн 1,565 хичээл, сурах бичиг 147, теле хичээл 4,024, интерактив контент 230, Интерактив дасгал ажлын хуудас 3,500, виртуал лаборатори 805, цахим ур чадвар олгох 413 хичээл нийт 20,000 гаруй контент байршаад байна. Мөн Боловсролын яам Польшийн "Learnetic" боловсролын технологийн компанитай хамтран ЕБС-ийн бага ангийн 33 сурах бичгийн бүх дасгал, даалгаврыг интерактив хэлбэрт шилжүүлсэн байна.

Зураг 4.59 Цахим контентын сан бүрдүүлэх болон цахим сургалт



Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод “Нээлттэй боловсролын тогтолцоог хөгжүүлж, цахим сургалтын нэгдсэн платформ бий болгон хүн бүр орон зай, цаг хугацаанаас үл хамааран өөрийн хүссэн чиглэлээр насан туршдаа суралцах боломжийг бүрдүүлсэн байна” тус тус заасан.

Боловсролын ерөнхий хуульд “Цахим сургалт” гэдгийг цахим технологи ашиглан зохион байгуулах сургалтын үйл ажиллагааг хэлнэ гэж тодорхойлон, боловсрол сургалтын хэлбэр нь танхимын танхимын бус, эдгээрийн хосолсон байж болохоор тусгасан бөгөөд танхимын бус сургалтад зайн, хувилбарт болон цахим, дадлага сургалт хамаарна гэж, Боловсролын цахим сургалтын байгууллагыг энэ хуульд заасан шаардлагын дагуу байгуулж болно гэж тус тус тусгасан нь цахим сургалтын эрх зүйн орчин бүрдсэн.

Бүлэг дүүргэлт, багшийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалан хөдөөгийн сургуулийн ахлах ангийн суралцагчдын дунд үүсдэг бэрхшээлийг арилгах, тэдэнд сонгон судлах хичээлээ судлах тэгш боломж олгох, хилийн чанадад байгаа монгол хүүхдэд монгол хэл, монголын түүх, соёл, үндэсний өв уламжлал, зан заншлаас сургах зорилгоор цахим сургуулийн үйл ажиллагааг 2022-2023 оны хичээлийн жилд туршилтаар БМТТ-ийн дэргэд эхлүүлсэн бөгөөд 2024-2025 оны хичээлийн жилд нийт ахлах ангийн сонгон судлах хичээлийн бүлэг бүрдээгүй 432 /нийслэл-114, аймгийн төв-102, сум-207, баг-8, Солонгос улс дахь-1/ сургуулийн 10-р ангийн 7,074, 11-р ангийн 5,531 сурагч, 12-р ангийн 4,848 сурагч, нийт 17,453 суралцагч цахим сургуульд суралцаж байна.



Салбарын 2025-2026 оны хөгжлийн төсөөлөл

Монгол Улсын хууль тогтоомж, хөгжлийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичиг, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан "Цахимжсан боловсрол"-ын бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна.

Цаашид боловсролын салбарын санхүүжилт, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг их өгөгдөл, хүн ам, орон зайн мэдээлэлд тулгуурлан оновчтой төлөвлөдөг болгох ба ахисан түвшний шинжилгээнд үндэслэн шийдвэр гаргадаг болгох, танхимын сургалтын хөтөлбөрийг цахим сургалтын хөтөлбөрт шилжүүлж, цахим сургалтын байгууллагыг хөгжүүлэх бөгөөд боловсрол сургалтын байгууллагад танхим, цахим хосолсон сургалтыг зохион байгуулах боломжийг бүрдүүлэх, иргэдийн насан туршийн суралцахуйн хүрээнд гэр бүл, хүүхдэд чиглэсэн сургалтын тогтолцоог бий болгож, хүн бүр орон зай, цаг хугацаанаас үл хамааран насан туршдаа суралцах цахим сургалтын боломжийг бий болгох, боловсролын салбарын багш, ажилтан хүний нөөцийн цахим ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулна.

Дээрх бодлогын баримт бичигт тусгагдсан хүн бүрд тэгш, хүртээмжтэй, чанартай боловсрол олгох, хилийн чанадад амьдарч байгаа хүүхдийн монгол хэл, түүх, соёлын хичээлийг сурч боловсрох эрхийг хангах зорилгоор цахим сургалтын байгууллага байгуулна.

Боловсрол сургалтын үйл ажиллагаанд хиймэл оюун ухаан, дэвшилтэд технологи нэвтрүүлэх, багш, суралцагч, эцэг эх асран хамгаалагч нарт зориулсан контентын санг баяжуулах бөгөөд насан туршийн боловсрол болон суралцагчийн ялгаатай хэрэгцээ, онцлогт тохирсон мэдээллийн технологийн хөтөлбөр, агуулгыг боловсруулж нэвтрүүлэх, хиймэл оюунд суурилсан интерактив сурах бичгийг хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна.

Боловсролын салбарын цахим дэд бүтцийг бүрэн шийдвэрлэж, боловсролын нэгдсэн сүлжээг өргөжүүлэн, танхим бүрд утастай болон утасгүй сүлжээнд холбогдох боломжийг бий болгох ба сургууль бүрд хүүхдийн тоо, хүчин чадлаас хамааруулан орчин үеийн цахим танхим байгуулах, цахим хуваагдлыг арилгах үүднээс суралцагч бүрд зөөврийн төхөөрөмж олгох хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар цахим сургалтын орчин бүрдүүлж, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангана.

Эдгээрийг хэрэгжүүлэхэд улсын төсвийн болон гадаад, дотоодын хандивлагч байгууллагын хөрөнгө оруулалтын дэмжлэг нэн тэргүүнд шаардлагатай байна.

Боловсролын салбарын мэдээллийн системийг боловсролын түвшин бүрд шинэчлэх, өргөжүүлэх, ашиглалтыг сайжруулах, мэдээллийн нууцлал аюулгүй байдлыг хангах, салбараас үзүүлж буй төрийн үйлчилгээг нэмэгдүүлэх, салбар доторх болон салбар хоорондын мэдээлэл солилцоог нэмэгдүүлэх замаар багш, ажилтны ажлын ачааллыг бууруулах, дотоодын болон олон улсын стандартыг үе шаттайгаар нэвтрүүлэх, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, Боловсролын салбарт гүйцэтгэлийн болон чанарын үнэлгээний тогтолцоог цахим хэлбэрт шилжүүлж, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог сайжруулна.

Салбарт тулгарч болзошгүй эрсдэл

Боловсролын сургалтын байгууллагад цахим технологи хариуцсан албан тушаалтан байхгүйгээс болон салбарын багш, ажилчдын цахим ур чадварын харилцан адилгүй байдлаас шалтгаалж “Цахимжсан боловсрол” бодлого хэрэгжилт удаашрах эрсдэлтэй.

Мөн боловсролын салбарт цахим технологийг нэвтрүүлэхэд дэд бүтцийн бэлэн байдлыг хангах, хүүхэд бүрд цахимаар суралцах тэгш боломжийг олгоход шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэхгүй тохиолдолд хот, хөдөө орон нутгийн ялгаатай байдал арилах боломжгүй юм.



05

МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ



2024 ОНЫ ОНЦЛОХ АЖИЛ:


“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын “2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” зэрэг бодлогын томоохон баримт бичгүүдэд хүн бүрд чанартай боловсрол, мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх, зөв хандлагыг төлөвшүүлэх, бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, үйлдвэрлэлийн хөгжлийн хэрэгцээтэй уялдуулан мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг төрөлжүүлэх, салбар дундын үйлдвэрлэл-дадлагын баазыг бий болгох зэрэг бодлого, зорилтууд тусгагдлаа.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 64 дүгээр тогтоолоор “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” батлагдаж Монгол Улсыг Хангайн, Баруун, Хойд, Төвийн, Зүүн, Говийн, Улаанбаатарын гэсэн бүсчлэлийн тогтолцооны дагуу 21 аймагт байрлах мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагуудыг төрөлжүүлнэ. Засгийн газраас хэрэгжүүлэх 14 мега төсөл, Үйлдвэрлэл технологийн паркийн төслүүд зэрэг томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэргэжилтэй ажилтан, нарийн мэргэжлийн инженер, техникийн ажилчдыг бүсчлэлийн хүрээнд бэлтгэн нийлүүлнэ.

Засгийн газрын 2024 оны 194 дүгээр тогтоолоор “Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам” шинэчлэгдэн батлагдаж тус сангийн 2024 оны үйл ажиллагааны тайлан, 2025 оны жилийн орлого, зарлагын төсвийн хуваарийг Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын зөвлөл хэлэлцлээ.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг их өгөгдөлд суурилан тооцоолж, шаардлагатай хүний нөөцийг бэлтгэхээр ажиллангаа суралцах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор “Хосмог сургалт, ажлын байран дахь сургалт зохион байгуулах журам”-ыг Боловсролын сайдын 2024 оны А/330 дугаар тушаалаар батлууллаа. 2024-2025 оны хичээлийн жилээс мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын 4 байгууллага аж ахуйн нэгж байгууллагатай хамтран хосмог сургалтыг хэрэгжүүлж, нийт 147 суралцагч суралцаж байна.

Цаашид хосмог сургалтыг улс орны бүтээн байгуулалт, ажил олгогчийн эрэлт хэрэгцээ, захиалга шаардлагын хүрээнд хэрэгжүүлэх бөгөөд сургалтын үйл ажиллагаанд үйлдвэр, компани, аж ахуйн нэгж, мэргэжлийн холбоод, бусад салбарын төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа нэн чухал байгаа юм.



Хүснэгт 5.1 Мэргэжлийн болон техникийн боловсролын үндсэн үзүүлэлт, 2024-2025

Үзүүлэлт	Нийт	Төрийн өмчийн	Хувийн өмчийн
СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА			
Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын тоо	70	41	29
Мэргэжлийн боловсролын сургууль	28	7	21
Политехник коллеж	39	31	8
Бусад	3	3	-
Үүнээс: Нийслэл	36	12	24
Орон нутаг	34	29	5
СУРАЛЦАГЧ			
Нийт суралцагчид	40,906	29,248	11,658
Үүнээс: Эрэгтэй	26,515	19,887	6,628
Эмэгтэй	14,391	9,361	5,030
Үүнээс: Нийслэл	20,517	10,528	9,989
Орон нутаг	20,389	18,720	1,669
Техникийн боловсрол	4,667	3,505	1,162
Мэргэжлийн боловсрол	34,747	24,271	10,476
Мэргэжлийн сургалт	1,492	1,472	20
Малчин өрхөөс суралцагч	9,353	7,576	1,777
Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч	653	425	228
Үүнээс: Эрэгтэй	389	251	138
Эмэгтэй	264	174	90
Төгсөх ангид суралцагч	20,645	14,304	6,341
Үүнээс: Эрэгтэй	12,435	9,170	3,265
Эмэгтэй	8,210	5,134	3,076
ШИНЭЭР ЭЛСЭГЧ			
Шинээр элсэгчид	22,358	15,635	6,723
Үүнээс: Эрэгтэй	13,810	10,313	3,497
Эмэгтэй	8,548	5,322	3,226
Үүнээс: Нийслэлд	10,877	5,649	5,228
Орон нутагт	11,481	9,986	1,495
Техникийн боловсрол	1,435	1,081	354
Мэргэжлийн боловсрол	19,431	13,082	6,349
Мэргэжлийн сургалт	1,492	1,472	20
Малчин өрхөөс шинээр элсэгч	4,824	3,693	1,131
БАГШ, АЖИЛТАН			
Нийт багш, ажилтан	3,878	3,122	756
Үүнээс: Эрэгтэй	3,122	1,087	2,035
Эмэгтэй	756	244	512
Үүнээс: Нийслэлд	1,350	689	661
Орон нутагт	2,528	2,433	95
Үндсэн багш	2,140	1,700	440
Үүнээс: Эрэгтэй	1,700	608	1,092
Эмэгтэй	440	141	299
Үүнээс: Нийслэлд	838	449	389
Орон нутагт	1,302	1,251	51


5.1 МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА



Монгол Улсын хэмжээнд 2024-2025 оны хичээлийн жилд мэргэжлийн боловсрол, техникийн боловсролын түвшинд сургалт эрхлэх тусгай зөвшөөрөлтэй **70** сургалтын байгууллага байгаагаас сургалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа **69** сургалтын байгууллага байна.

Нийт мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын **41** буюу **58.6** хувь нь төрийн өмчийн, **29** буюу **41.4** хувь нь хувийн өмчийнх байна.

Зураг 5.1 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын тоо, өмчийн хэлбэрээр, хувиар




Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагаас Боловсролын яаманд харьяалагддаг **38** /үүнээс бие даасан-**26**, төрийн өмчийн их сургуулийн харьяа-**12**/, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд харьяалагддаг -**1**, ШШГЕГ-ын харьяа-**1**, “УБТЗ ХНН”-ийн харьяа-**1**, хувийн өмчийн-**29** сургалтын байгууллага /үүнээс “Барилгын бүтээц үйлдвэрлэл” МБС үйл ажиллагаа явуулаагүй/ байна.

Хүснэгт 5.2 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага, хэв шинж, байршлаар

Үзүүлэлт		2023-2024 оны хичээлийн жил			2024-2025 оны хичээлийн жил		
		Нийт	Төрийн өмчийн	Хувийн өмчийн	Нийт	Төрийн өмчийн	Хувийн өмчийн
Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага		76	48	28	70	41	29
Хэв шинж	Мэргэжлийн боловсролын сургууль	40	20	20	28	7	21
	Политехник коллеж	33	25	8	39	31	8
	Бусад	3	3	-	3	3	-
Байршил	Үүнээс: Нийслэлд	36	13	23	36	13	23
	Орон нутагт	40	35	5	34	29	5

Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагаас **28** буюу **40.0** хувь нь мэргэжлийн боловсролын сургууль, **39** буюу **55.7** хувь нь политехник коллеж, **3** буюу **4.3** хувь нь бусад хэв шинж бүхий сургалтын байгууллага байна /Сэргээн Засалт, Сургалт Үйлдвэрлэлийн Төвийн Мэргэжлийн Боловсрол, Ур Чадвар Олгох Сургууль, Монгол Улсын консерватор, Монгол Улсын консерваторын харьяа Завхан аймаг дахь Хөгжим бүжгийн коллеж/.

Зураг 5.2 Нийслэл, орон нутаг дахь мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын тоо




Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын **34** буюу **48.6** хувь нь орон нутагт, **36** нь буюу **51.4** хувь нь нийслэлд үйл ажиллагаа явуулж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 306 дугаар тогтоолоор төрийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын **18** сургалтын байгууллагыг өөрчлөн зохион байгуулж дараах **10** сургалтын байгууллага болгосон. 2024-2025 оны хичээлийн жилээс нэгтгэсэн зохион байгуулалтын хэлбэрээр сургалтын үйл ажиллагаа явуулж байна.

Засгийн газрын 306 дугаар тогтоолоор өөрчлөн зохион байгуулагдсан сургалтын байгууллагууд	
Өөрчлөн зохион байгуулагдахаас өмнөх сургалтын байгууллага	Өөрчлөн зохион байгуулагдсан сургалтын байгууллага
Булган аймаг дахь МСҮТ	Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Булган аймаг дахь Политехник коллеж
Булган аймаг дахь ХАА МСҮТ	
Сэлэнгэ аймаг дахь МСҮТ	
Сэлэнгэ аймгийн Шаамар суман дахь МСҮТ	Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Сэлэнгэ аймаг дахь Политехник коллеж
Төв аймгийн Заамар суман дахь МСҮТ	Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Төв аймаг дахь Политехник коллеж
ХҮИС-ийн дэргэдэх МСҮТ	Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа политехник коллеж
ШУТИС-УТС-ийн дэргэдэх МСҮТ	
ШУТИС-МТС-ийн дэргэдэх МСҮТ	
Өмнөговь аймаг дахь политехник коллеж	Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн харьяа политехник коллеж
Хөвсгөл аймаг дахь политехник коллеж	Шинжлэх ухаан технологийн их сургуулийн харьяа Хөвсгөл аймаг дахь политехник коллеж
ҮБХИС-ийн харьяа Батлан хамгаалахын мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв	Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн харьяа Батлан хамгаалахын политехник коллеж
Дархан-Уул аймаг дахь "Дархан Өргөө" политехник коллеж	Дархан-Уул аймаг дахь "Дархан" политехник коллеж
Дархан-Уул аймаг дахь политехник коллеж	
Дархан-Уул аймаг дахь Уул уурхай эрчим хүчний политехник коллеж	
Орхон аймаг дахь МСҮТ	Орхон аймаг дахь Политехник коллеж
Орхон аймаг дахь ХАА-н МСҮТ	
Дорнод аймаг дахь политехник коллеж	Дорнод аймаг дахь политехник коллеж
Дорнод аймаг дахь МСҮТ	

5.2 МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН СУРАЛЦАГЧ

Зураг 5.3 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын нийт суралцагч, өмчийн хэлбэр, хувиар



Мэргэжлийн болон техникийн боловсролын түвшинд сургалтын үйлжиллагаа явуулж буй сургалтын байгууллагад 2024-2025 оны хичээлийн жилд **40,906** суралцагч суралцаж байгаагаас **29,248** буюу **71.5** хувь нь төрийн өмчийн, **11,658** буюу **28.5** хувь нь хувийн өмчийн сургалтын байгууллагад суралцаж байна.

Зураг 5.4 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагч, хүйсээр




Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчдыг хүйсээр авч үзвэл, нийт суралцагчдын **14,391** буюу **35.2** хувийг эмэгтэй, **26,515** буюу **64.8** хувийг эрэгтэй суралцагч эзэлж байна.

Жендерийн тэнцвэрт байдлын индекс буюу **100** эрэгтэй суралцагч тутамд ногдох эмэгтэй суралцагчийн тоо **50** болж өмнөх хичээлийн жилээс **0.5**-оор пунктээр буурсан байна.





Зураг 5.5 Мэргэжлийн болон техникийн боловсролын салбарын суралцагчдын хүйсийн тэнцвэрт байдлын индекс, хувиар




● Нийт суралцагчдад эмэгтэй суралцагчийн эзлэх хувь ● Хүйсийн тэнцвэрт байдлын индекс

Зураг 5.6 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчдын тоо, нутаг дэвсгэрийн байршлаар



Нийт суралцагчийн **20,517** буюу **50.2** хувь нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй **35** сургалтын байгууллагад, **20,389** буюу **49.8** хувь нь орон нутгийн **34** сургалтын байгууллагад суралцаж байна. Аймагаар авч үзвэл, 2024-2025 оны хичээлийн жилд хамгийн олон суралцагчтай нь Дархан-Уул аймаг дахь Дархан политехник коллежид **2,208**, хамгийн цөөн суралцагчтай нь Говь-Алтай аймаг дахь мэргэжлийн боловсролын сургуульд **321** суралцагч суралцаж байна.


Зураг 5.7 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын нийт суралцагчид, оноор



Хүснэгт 5.3 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчид, хөтөлбөрөөр, 2024-2025 оны хичээлийн жилийн эхний хагас жилд

Д/д	Ерөнхий чиглэл	Хөтөлбөрийн тоо	Нийт суралцагчид	Үүнээс:			Хувь
				Техникийн боловсрол	Мэргэжлийн боловсрол	Мэргэжлийн сургалт	
1	Урлаг, хүмүүнлэг	19	3113	352	2725	36	7.6%
2	Нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл сэтгүүл зүй	1	17	0	17	0	0.04%
3	Бизнес, удирдлага, эрх зүй	4	1334	64	1259	11	3.3%
4	Мэдээлэл, харилцаа холбооны технологиуд	6	1279	178	1099	2	3.1%
5	Инженерчлэл, үйлдвэрлэл, барилга байгууламж	47	24504	2667	21074	763	59.9%
6	Хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй, мал эмнэл зүй	8	2025	449	1576	0	5.0%
7	Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал	3	264	0	244	20	0.6%
8	Үйлчилгээ	12	8370	957	6753	660	20.5%
Дүн		100	40906	4667	34747	1492	100%


Зураг 5.8 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчид, хөтөлбөрөөр, хүйсээр, 2024-2025 оны хичээлийн жилийн эхний хагас жилд



Нийт суралцагчдыг хөтөлбөрөөр авч үзвэл, 2024-2025 оны хичээлийн жилд инженерчлэл, үйлдвэрлэл, барилга байгууламж ерөнхий чиглэлийн хамгийн их буюу **47** хөтөлбөрийг нийт суралцагчдын **59.9** хувь нь, үйлчилгээний ерөнхий чиглэлийн **12** хөтөлбөрийг нийт суралцагчдын **20.5** хувь нь тус тус сонгон суралцаж байгаа бол хамгийн бага суралцагчтай нь нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл сэтгүүл зүй ерөнхий чиглэлийн **1** хөтөлбөрийг нийт суралцагчдын **0.04** хувь нь тус тус сонгож суралцаж байна.



Зураг 5.9 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчид, насаар, 2024-2025 оны хичээлийн жилийн эхний хагас жилд



Нийт суралцагчдын 23,539 буюу 57.5 хувийг 15-17, 5,761 буюу 14.1 хувийг 17-20, 2,683 буюу 6.6 хувийг 21-25, 1,780 буюу 4.4 хувийг 26-29, 3,109 буюу 7.6 хувийг 30-35, 1,845 буюу 4.5 хувийг 36-39, 2,189 буюу 5.4 хувийг 40 ба түүнээс дээш насныхан эзэлж байна.

Нийт 40,906 суралцагчаас **18** хүртэлх насны суралцагчид **26,964** байна. 18 хүртэлх насны суралцагчаас хагас өнчин **2,291** буюу нийт суралцагчийн **5.6** хувийг, бүтэн өнчин **276** буюу нийт суралцагчийн **0.7** хувийг эзэлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй **653** суралцагч сурч байгаа нь нийт суралцагчийн **1.6** хувийг эзэлж байна.

Зураг 5.10 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад суралцаж буй нийт хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид, хөгжлийн бэрхшээлийн төрлөөр, 2024-2025 оны хичээлийн жилийн эхний хагас жилд




Шинээр элсэгчид. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад 2024-2025 оны хичээлийн жилийн эхний хагас жилд **22,358** суралцагч шинээр элссэн байна. Нийт шинээр элсэгчдийн **8,548** буюу **38.2** хувь нь эмэгтэй, **13,810** буюу **61.8** хувь нь эрэгтэй суралцагч байна. Жендерийн тэнцвэрт байдлын индекс буюу **100** эрэгтэй шинээр элсэгч тутамд ногдох эмэгтэй шинээр элсэгчийн тоо **61** байна.

Хүснэгт 5.4 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын нийт элсэгчдийн тоо

Үзүүлэлт	2020/ 2021	2021/ 2022	2022/ 2023	2023/ 2024	2024/ 2025
Нийт шинээр элсэгч	24,628	25,264	19,256	21,199	22,358
Үүнэс: Эмэгтэй	10,613	11,087	7,779	8,386	8,548
Эрэгтэй	14,015	14,177	11,477	12,813	13,810
Шинээр элсэгчдийн дотор тухайн жилд 9-р анги төгсөгчийн тоо	9,095	7,966	7,827	9,218	9,907
Шинээр элсэгчдийн дотор тухайн жилд 12-р анги төгсөгчийн тоо	2,112	1,575	1,356	2,202	2,533
Ажиллагчдаас	2,363	2,179	1,700	2,319	1,649
Ажилгүй иргэдээс	8,905	11,282	6,677	6,100	5,936
Бусад	2,153	2,262	1,696	1,360	2,333

Зураг 5.11 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын нийт элсэгчид, хүйсээр



Шинээр элсэгчдийн **9,907** буюу **44.3** хувь нь тухайн жилд ерөнхий боловсролын **9** дүгээр ангийг төгссөн суурь боловсрол эзэмшигчээс, **2,533** буюу **11.3** хувь нь тухайн жилд ерөнхий боловсролын 12 дугаар анги төгссөн бүрэн дунд боловсрол эзэмшигчээс, **5,936** буюу **26.5** хувь нь ажилгүй иргэдээс, **1,649** буюу **7.4** хувь нь ажиллагчдаас, **2,333** буюу **10.4** хувь нь бусад хүрээнээс элссэн байна.



Хүснэгт 5.5 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын шинээр элсэгч, суралцагч, төгсөх ангид суралцагчид, хөтөлбөрөөр, хүйсээр, 2024-2025 оны хичээлийн жилийн эхний хагас жилд

№	Ерөнхий чиглэл	Шинээр элсэгчид		Техникийн боловсрол		Мэргэжлийн боловсрол		Мэргэжлийн сургалт	
		Бүгд	Эм	Бүгд	Эм	Бүгд	Эм	Бүгд	Эм
1	Урлаг, хүмүүнлэг	1,220	604	80	50	1,104	554	36	0
2	Нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл сэтгүүл зүй	17	16	0	0	17	16	0	0
3	Бизнес, удирдлага, эрх зүй	975	769	24	22	940	738	11	9
4	Мэдээлэл, харилцаа холбооны технологиуд	612	279	65	29	545	249	2	1
5	Инженерчлэл, үйлдвэрлэл, барилга байгууламж	12,959	3,100	856	154	11,340	2,863	763	83
6	Хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй, мал эмнэл зүй	1,538	745	138	46	1,400	699	0	0
7	Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал	256	226	0	0	236	206	20	20
8	Үйлчилгээ	4,781	2,809	272	152	3,849	2,403	660	254
Дүн		22,358	8,548	1,435	453	19,431	7,728	1,492	367

№	Ерөнхий чиглэл	Суралцагчид		Техникийн боловсрол		Мэргэжлийн боловсрол		Мэргэжлийн сургалт	
		Бүгд	Эм	Бүгд	Эм	Бүгд	Эм	Бүгд	Эм
1	Урлаг, хүмүүнлэг	3,113	1,523	352	172	2,725	1,351	36	0
2	Нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл сэтгүүл зүй	17	16	0	0	17	16	0	0
3	Бизнес, удирдлага, эрх зүй	1,334	1,072	64	59	1,259	1,004	11	9
4	Мэдээлэл, харилцаа холбооны технологиуд	1,279	548	178	75	1,099	472	2	1
5	Инженерчлэл, үйлдвэрлэл, барилга байгууламж	24,504	5,125	2,667	528	21,074	4,514	763	83
6	Хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй, мал эмнэл зүй	2,025	898	449	159	1,576	739	0	0
7	Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал	264	231	0	0	244	211	20	20
8	Үйлчилгээ	8,370	4,978	957	548	6,753	4,176	660	254
Дүн		40,906	14,391	4,667	1,541	34,747	12,483	1,492	367

№	Ерөнхий чиглэл	Төгсөх ангид суралцагчид		Техникийн боловсрол		Мэргэжлийн боловсрол		Мэргэжлийн сургалт	
		Бүгд	Эм	Бүгд	Эм	Бүгд	Эм	Бүгд	Эм
1	Урлаг, хүмүүнлэг	1,189	542	192	87	961	455	36	0
2	Нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл сэтгүүл зүй	17	16	0	0	17	16	0	0
3	Бизнес, удирдлага, эрх зүй	847	663	29	27	807	627	11	9
4	Мэдээлэл, харилцаа холбооны технологиуд	412	230	92	40	318	189	2	1
5	Инженерчлэл, үйлдвэрлэл, барилга байгууламж	11,913	3,138	1,531	318	9,619	2,737	763	83
6	Хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй, мал эмнэл зүй	1,509	734	201	78	1,308	656	0	0
7	Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал	251	229	0	0	231	209	20	20
8	Үйлчилгээ	4,507	2,658	594	342	3,253	2,062	660	254
Дүн		20,645	8,210	2,639	892	16,514	6,951	1,492	367

5.4

МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ТӨГСӨГЧИД

Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын техникийн боловсрол, мэргэжлийн боловсрол, мэргэжлийн сургалтыг 2023-2024 оны хичээлийн жилд нийт **18,530** суралцагч төгсөж, өмнөх оны төгсөгчдөөс **1410-аар** буюу **7.1** хувиар буурсан үзүүлэлттэй байна. Мэргэжлийн боловсролын **2.5** жилийг **6,611** суралцагч, **1** жилийн ангийг **9,402** суралцагч, техникийн боловсролын **1.5** жилийн ангийг **1,725**, **3** жилийн ангийг **508**, мэргэжлийн сургалт буюу богино хугацаат сургалтыг **284** суралцагч тус тус төгссөн байна.



Мэргэжлийн болон техникийн боловсролын салбарын 2022-2023 оны төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Боловсролын ерөнхий газар болон Боловсрол, шинжлэх ухааны яамны Цахим бодлого, статистик мэдээллийн газар хамтран зохион байгууллаа.


5. МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ

Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааны зорилго нь мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, ажлын байранд зуучлагдаж буй хэлбэр, хугацаа, түүнчлэн дараагийн боловсролын түвшинд элссэн төгсөгчийн элссэн боловсролын түвшин зэргийг тодорхойлох, салбарын бодлого боловсруулагчид, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг төгсөгчийн хөдөлмөр эрхлэлтийн талаарх тоон мэдээллээр хангахад оршино.

Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагаар мэргэжилтэй ажилтан бэлтгэх мэргэжлийн нэр, индекс, сургалтын хөтөлбөрийг Олон Улсын жишигт нийцүүлэн сургалтад Олон Улсын Пийрсон, ВТЕС, Коосэн хөтөлбөрүүдийг судлан нэвтрүүлж, мэргэжлийн боловсролын 2,5 жилийн сургалтын хугацааг 3 жил болгон стандарт, хөтөлбөр, агуулгын шинэчлэлийг хэрэгжүүлээд байна. Монгол Улсын Их Хурлаар 2023 онд Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийг шинэчлэн баталсан. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын 76 байгууллагад 2023- 2024 оны хичээлийн жилд 38.294 суралцагч суралцаж байгаагаас 26.828 буюу 70,1 хувь нь төрийн өмчийн, 11.466 буюу 29,9 хувь нь хувийн өмчийн сургалтын байгууллагад суралцаж байна. Мэргэжлийн салбараар авч үзвэл, аж үйлдвэрийн салбарын 40 мэргэжлээр нийт суралцагчдын 31,4 хувь, барилгын салбарын 27 мэргэжлээр суралцагч 19,1 хувь нь тус тус сонгон суралцаж байгаа нь дийлэнх хувийг эзэлж байгаа бол боловсролын салбар, шуудан харилцаа холбооны чиглэлээр суралцагчид 0,2 хувийг эзэлж байна. 2022-2023 оны хичээлийн жилд Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын 76 байгууллагыг 19.940 суралцагч 16 салбарын 218 мэргэжлээр ур чадвар эзэмшин төгссөн ба 12.593 суралцагч буюу 63,2 хувь нь мэргэжлээрээ ажиллаж байна.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгааны 2023 оны тайланд ажиллах хүчний нийт эрэлтийн 1,0 хувийг үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан, 5,1 хувийг барилгын туслах ажилтан, 3,6 хувийг худалдагч, 3,0 хувийг цэвэрлэгч, үйлчлэгч зэрэг ажил мэргэжлүүд эзэлж байна. Эдгээр ажил мэргэжлийн эрэлт багагүй хувийг эзэлдэг бөгөөд нийт эрэлтийн 21,7 хувийг бүрдүүлж байна. Түүнчлэн засал, шаварчин, жолооч, оёдолчин, мужаан, тогооч, зөөгч, гагнуурчин, цахилгаанчин, сантехникч зэрэг мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагаар бэлтгэдэг ажил мэргэжлийн эрэлт их байна.

Зураг 5.12 2022-2023 оны хичээлийн жилийн төгсөгчид, судалгаанд оролцогчдын тоо



2022-2023 оны хичээлийн жилд Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын 76 байгууллагыг 19.940 суралцагч 16 салбарын 218 мэргэжлээр ур чадвар эзэмшин төгссөн.



2023 онд төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт нь 1 жилийн дараа буюу 2024 оны 12 дугаар сарын байдлаар нийт төгсөгчдийн 79.1 хувь нь мэргэжлээрээ ажиллаж байгаа болон дараагийн шатны боловсролын түвшинд суралцаж байна. Үүнээс 62.3 хувь нь мэргэжлээрээ хөдөлмөр эрхэлж, 16.8 хувь нь дараагийн боловсролын түвшинд элсэн суралцсан байна. Ийнхүү 2023 оны төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт өмнөх хичээлийн жилийн хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгчдөөс 3.0 хувиар өссөн байна

Зураг 5.13 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын 2022-2023 оны хичээлийн жилийн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт, дараагийн боловсролын түвшинд суралцсан төгсөгч /хувиар/



Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын 12.593 төгсөгч буюу 63.2 хувь нь ажил хөдөлмөр эрхэлж байна. Тухайлбал, мэргэжлээрээ ажиллаж байгаа 6.640 (52,7%), эзэмшсэн мэргэжлээс өөр ажил эрхэлж байгаа төгсөгч 4791 (38,0%), өөртөө ажлын байр бий болгон ажиллаж байгаа төгсөгч 936 (7,4%), гадаад улсад ажил хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгч 226 (1,8%) байна.

Эх үүсвэр: ХНХЯ, Хөдөлмөрийн зах зээлийн тойм 2024 оны III улирал


Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг төгсөөд дараагийн боловсролын түвшинд буюу дээд сургуульд 797 (32,1%), техникийн боловсролд 976 (39,3%), гадаадад 200 (8.0%), бусад 512 (20.6%) төгсөгч байна.



Хүснэгт 5.6 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын 2022-2023 оны хичээлийн жилийн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа, сургалтын байгууллагын өмчийн хэлбэрээр, 2023 оны 12 дугаар сарын байдлаар

	Судалгаанд хамрагдсан төгсөгчийн тоо	Ажлын байртай болсон төгсөгч						Дараагийн боловсролын түвшинд элссэн төгсөгч				
		Бүгд	Мэргэжлээрээ ажиллаж байгаа төгсөгч	Эзэмшсэн мэргэжлээс өөр ажил эрхэлж байгаа төгсөгч	Өөртөө ажлын байр бий болгон ажиллаж байгаа төгсөгч	Гадаадын улсад ажил хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгч	Бүгд	Дээд боловсрол	Техникийн боловсрол	Гадаадын улсад суралцаж байгаа төгсөгч	Бусад	
Бүгд	70	19203	12593	6640	4791	936	226	2562	799	984	200	579
Төрийн өмчийн коллеж	29	11382	7550	4143	2744	542	121	1642	487	685	137	333
Төрийн бус өмчийн коллеж	8	3035	2064	1026	907	63	68	471	109	273	24	65
Төрийн өмчийн МБС	9	2232	1078	500	487	87	4	186	41	21	5	119
Төрийн бус өмчийн МБС	21	2385	1827	919	639	241	28	185	100	3	21	61
Төрийн өмчийн бусад хэв шинж бүхий сургалтын байгууллага	3	169	74	52	14	3	5	78	62	2	13	1

Зураг 5.14 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын 2022-2023 оны хичээлийн жилийн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт, дараагийн боловсролын түвшинд суралцсан төгсөгч, хувиар



ТӨГСӨГЧИД БА ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ

Хүснэгт 5.7 Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчид, 2022-2023 оны хичээлийн жилд

Салбар, дэд салбар	Нийт төгсөгчид
Бүгд	18,530
I.Боловсролын салбар	32
II.Соёл, урлагийн салбар	994
III.Цагдаа, батлан хамгаалах, онцгой байдлын салбар	218
IV.Санхүү, бизнес, худалдааны салбар	439
V.Мэдээллийн технологийн салбар	999
VI.Шуудан, харилцаа холбооны салбар	40
VII.Байгаль орчин, аялал жуулчлалын салбар	788
VIII.Барилгын салбар	3,469
IX.Тээврийн салбар	2,310
X.Эрчим хүчний салбар	149
XI.Уул уурхайн салбар	1,231
XII.Хөдөө аж ахуйн салбар	1,051
XIII.Аж үйлдвэрийн салбар	5,475
XIV.Хот байгуулалт, тохижилтын салбар	116
XV.Үйлчилгээний салбар	1,035
XVI.Эрүүл мэндийн салбар	184

Хүснэгт 5.8 Эрэлттэй мэргэжил, хувиар

Д/д	ISCO код	Ажил мэргэжлийн нэр	Дүнд эзлэх хувь
1	932912	Үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан	10.0
2	931211	Туслах ажилтан, барилгын туслах	5.1
3	521111	Мухлаг /лангууны худалдагч	3.6
4	911211	Цэвэрлэгч, албан тасалгааны	3.0
5	832211	Жолооч, машины	3.0
6	753311	Оёдолчин, зөөлөн эдлэлийн	2.3
7	712311	Засалчин, шаварчин	2.2
8	343411	Тогооч	1.8
9	122111	Дарга, эрхлэгч / менежер/, алба, хэлтэс, тасгийн / борлуулалтын/	1.7
10	522312	Худалдаачин /бөөний газрын/	1.6
11	241117	Нягтлан бодогч, тооцооны	1.6
12	752222	Нарийн мужаан	1.5
13	721214	Гагнуурчин	1.3
14	513111	Зөөгч	1.3
15	214112	Инженер, байгууламжийн	1.2
16	741111	Цахилгаанчин	1.2
17	712619	Сантехникч, сантехникийн системийн эд анги, зангилааг бэлтгэх	1.2
18	225011	Малын эмч	1.2
19	142016	Менежер, бөөний худалдааны / захиалгаар үйлчлэх дэлгүүрийн/	1.0
20	731121	Засварчин, багажны / нарийн/	0.9

Хүснэгт 5.9 Эрэлттэй мэргэжил, оноор

2024 онд эрэлттэй байх ажил мэргэжил		2023 онд эрэлттэй байх ажил мэргэжил	
ISCO код	Ажил мэргэжлийн нэр	ISCO код	Ажил мэргэжлийн нэр
932912	Үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан	712311	Засалчин, шаварчин
931211	Туслах ажилтан, барилгын туслах	911211	Цэвэрлэгч/үйлчлэгч, албан тасалгааны
521111	Мухлаг /лангууны худалдагч	932912	Үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан
911211	Цэвэрлэгч, албан тасалгааны	833212	Операторч, хүнд даацын авто машины
832211	Жолооч, машины	931211	Туслах ажилтан, барилгын туслах
753311	Оёдолчин, зөөлөн эдлэлийн	521111	Мухлаг /лангууны худалдагч
712311	Засалчин, шаварчин	322101	Туслах сувилагч
343411	Тогооч	241112	Нягтлан бодогч
122111	Дарга, эрхлэгч /менежер/, алба, хэлтэс, тасгийн /борлуулалтын/	832211	Жолооч, машины
522312	Худалдаачин /бөөний газрын/	231038	Багш, англи хэлний
241117	Нягтлан бодогч, тооцооны	142012	Менежер, бөөний худалдааны / дэлгүүрийн/
752222	Нарийн мужаан	711515	Мужаан, засварын
721214	Гагнуурчин	226201	Эм зүйч
513111	Зөөгч	343411	Тэргүүлэх шеф тогооч /Head chef/
214112	Инженер, байгууламжийн	214417	Инженер, дотоод шаталтат хөдөлгүүрийн
741111	Цахилгаанчин	933316	Ачигч, дэлгүүрийн
712619	Сантехникч, сантехникийн системийн эд анги, зангилааг бэлтгэх	225011	Малын эмч
225011	Малын эмч	721214	Гагнуурчин
142016	Менежер, бөөний худалдааны / захиалгаар үйлчлэх дэлгүүрийн/	711411	Арматурчин
731121	Засварчин, багажны /нарийн/	723119	Автомашин хөдөлгүүрийн засварчин, моторчин

Эх үүсвэр: ХНХЯ, ХСИ, "Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгааны 2024 оны үр дүнгийн тайлан"

5.5


МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН БАГШ, АЖИЛЛАГЧИД

Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад 2024-2025 оны хичээлийн жилд нийт **3,878** ажилтан ажиллаж байгаагаас төрийн өмчийн сургалтын байгууллагад **3,122**, хувийн өмчийн сургалтын байгууллагад **756** багш, ажилтан ажиллаж байна.

Хүснэгт 5.10 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын нийт багш, ажиллагчид, хүйс, албан тушаалаар

Үзүүлэлт	2020/ 2021	2021/ 2022	2022/ 2023	2023/ 2024	2024/ 2025
Нийт ажиллагчид	4,061	3,944	4,094	4,168	3,878
эмэгтэй	2,605	2,559	2,680	2,729	2,547
эрэгтэй	1,456	1,385	1,414	1,439	1,331
Үндсэн багш	2,242	2,124	2,252	2,351	2,140
Бусад ажиллагчид	1,652	1,649	1,686	1,660	1,484
Захирал	94	97	81	81	75
Сургалтын албаны дарга	73	74	75	76	73


Зураг 5.15 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын нийт багш, ажилтан, хүйс, албан тушаалаар



Нийт ажилтны **2,547** буюу **65.7** хувь нь эмэгтэй, **1,331** буюу **34.3** хувь нь эрэгтэй ажилтан байна. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын нийт ажилтны дотор үндсэн багш **2,140** буюу **55.2** хувь, захирал болон дэд захирал **75** буюу **2.0** хувь, сургалтын менежер **73** буюу **1.9** хувь, бусад ажилтан **1,484** буюу **38.3** хувийг тус тус эзэлж байна.



Зураг 5.16 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын нийт үндсэн багш




2024-2025 оны хичээлийн жилд нийт ажилтны **2,140** буюу **55.2** хувийг үндсэн багш эзэлж байна.

Үндсэн багшийн **1,350** буюу **63.0** хувь нь мэргэжлийн, **790** буюу **36.9** хувь нь ерөнхий эрдмийн багш байна.

Нийт багшийн **1,391** буюу **65.0** хувь нь эмэгтэй, **749** буюу **35.0** хувь нь эрэгтэй багш байна.



Зураг 5.17 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын үндсэн багш, өмчийн хэлбэрээр




Нийт үндсэн багшийн **1,700** буюу **79.4** хувь нь төрийн өмчийн, **440** буюу **20.6** хувь нь хувийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын үндсэн багш байна.



Хүснэгт 5.11 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын үндсэн багшийг нас, өмчийн хэлбэрээр, 2024-2025

Багшийн нас	Үндсэн багш	Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага	
		Төрийн өмчийн	Хувийн өмчийн
Сургалтын байгууллага	70	41	29
Үндсэн багш	2,140	1,700	440
30 хүртэл	312	205	107
30-39	863	711	152
40-49	641	563	78
50-59	249	205	44
60, түүнээс дээш	75	16	59

Зураг 5.18 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багшийн нас, өмчийн хэлбэрээр, 2024-2025**Хүснэгт 5.12 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын үндсэн багшийн боловсролын түвшин, өмчийн хэлбэрээр, 2024-2025**

Багшийн нас	Үндсэн багш	Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллага	
		Төрийн өмчийн	Хувийн өмчийн
Сургалтын байгууллага	70	41	29
Үндсэн багш	2,140	1,700	440
Доктор	26	15	11
Магистр	956	794	162
Бакалавр	1,027	795	232
Диплом	119	88	31
Бусад *	12	8	4
Багшлах эрхтэй багш	2,003	1,659	344

* Бусад гэсэн хэсэгт Хөдөлмөр, нийгмийн хамгаалын сайдын 2021 оны А/71 дүгээр тушаалаар батлагдсан "Багшлах эрх олгох, хасах журам"-ын 3.1.2-д "Үйлдвэрлэлийн зохих дадлага, туршлагатай, мэргэжлийн өндөр зэрэгтэй" багшийг оруулан тооцсон.

Зураг 5.19 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын үндсэн багшийн боловсролын түвшин




Үндсэн багшийн **1,027** буюу **48.0** хувь нь бакалавр, **956** буюу **44.7** хувь нь магистр, **119** буюу **5.6** хувь нь диплом, **0.6** хувь нь бусад, **26** буюу **1.2** хувь нь докторын зэрэгтэй байна.

Нийт үндсэн багшийн 2003 буюу **93.9** хувь нь багшлах эрхтэй.



Зураг 5.20 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын нийт багш, ажилтан, албан тушаалаар, 2024-2025





06

ДЭЭД БОЛОВСРОЛ



2024 ОНЫ ОНЦЛОХ АЖИЛ:

Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг соёрхон батлуулснаар Нэгдсэн үндэстний байгууллагаас дээд боловсролын салбарыг хамарсан анхны дэлхийн хэмжээний гэрээнд нэгдсэн 34 дэх улс боллоо. Энэхүү конвенц нь нэгдэн орсон улс орнуудын их, дээд сургуулиудын боловсрол, сургалтын үр дүн, зэрэг, цолыг ил тод, шударгаар хүлээн зөвшөөрөх, суралцагчдад бусад орны их, дээд сургуулиудад үргэлжлүүлэн суралцах, хөдөлмөр эрхлэх, зайн хэлбэрээр суралцаж, эзэмшсэн мэргэшлээ хүлээн зөвшөөрүүлэх боломжийг манай улсын иргэдэд олгож байгаа юм.

Ирэх 4 жилд бид хэрэгжүүлэх арга хэмжээний дотор “Техникийн болон дээд боловсролын шаталсан тогтолцоо бүхий сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн цогцолбор их сургууль, төрөлжсөн коллежийг бүсүүдэд хотхон хэлбэрээр хөгжүүлэх” арга хэмжээ тусгагдсан нь онцлогтой.




Хүснэгт 6.1 Дээд боловсролын үндсэн зүүүлэлт, 2024-2025

Үзүүлэлт	Бүгд	Нийслэл	Орон нутаг	Төрийн өмчийн	Хувийн өмчийн	Олон нийтийн/шашны өмчийн
СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА						
Нийт их, дээд сургууль, коллеж	65	60	5	17	45	3
Үүнд: Коллеж	2	1	1	2	0	0
Дээд сургууль	29	25	4	5	23	1
Их сургууль	34	34	0	10	22	2
Магадлан итгэмжлэгдсэн сургууль	62	59	3	14	45	3
Үүнд: Коллеж	0	0	0	0	0	0
Дээд сургууль	28	25	3	4	23	1
Их сургууль	34	34	0	10	22	2
СУРАЛЦАГЧ						
Нийт суралцагч	150,282	73,399	76,883	81,571	60,111	8,600
Үүнээс: эрэгтэй	58,021	29,466	28,555	32,967	21,847	3,207
эмэгтэй	92,261	43,933	48,328	48,604	38,264	5,393
Диплом	2,620	940	1,680	1,706	914	0
Үүнээс: эрэгтэй	512	261	251	325	187	0
эмэгтэй	2,108	679	1,429	1,381	727	0
Бакалавр	117,344	54,305	63,039	63,264	47,772	6,308
Үүнээс: эрэгтэй	46,547	22,686	23,861	26,324	17,872	2,351
эмэгтэй	70,797	31,619	39,178	36,940	29,900	3,957
Магистр	24,830	14,638	10,192	12,850	9,808	2,172
Үүнээс: эрэгтэй	8,631	5,039	3,592	4,685	3,139	807
эмэгтэй	16,199	9,599	6,600	8,165	6,669	1,365
Доктор	5,488	3,516	1,972	3,751	1,617	120
Үүнээс: эрэгтэй	2,331	1,480	851	1,633	649	49
эмэгтэй	3,157	2,036	1,121	2,118	968	71
ШИНЭЭР ЭЛСЭГЧ						
Нийт шинээр элсэгч	23,703	23,252	451	16,097	6,735	871
Үүнээс: эрэгтэй	9,074	8,870	204	6,815	1,904	355
эмэгтэй	14,629	14,382	247	9,282	4,831	516
Диплом	489	489	0	423	66	0
Бакалавр	20,312	19,921	391	14,053	5,403	856
Магистр	2,632	2,572	60	1,443	1,174	15
Доктор	270	270	0	233	37	0
БАГШ, АЖИЛЛАГЧИД						
Нийт багш, ажилтан	11,403	11,048	355	7,019	3,991	393
Үүнээс: эрэгтэй	4,058	3,936	122	2,470	1,451	137
эмэгтэй	7,345	7,112	233	4,549	2,540	256
Үндсэн багш	5,151	5,015	136	3,308	1,684	159
Үүнээс: эрэгтэй	2,008	1,969	39	1,277	656	75
эмэгтэй	3,143	3,046	97	2,031	1,028	84

6.1 ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА


Монгол Улсын хэмжээнд 2024-2025 оны хичээлийн жилд дээд боловсролын сургалтын **65** байгууллагад **150,282** оюутан суралцаж, **11,403** багш, ажиллагчид ажиллаж байна.

Зураг 6.1 Дээд боловсролын сургалтын байгууллага, ангиллаар



Дээд боловсролын сургалтын **65** байгууллагаас **34** буюу **52.3** хувь нь их сургууль, **29** буюу **44.6** хувь нь дээд сургууль, **2** буюу **3.1** хувь нь коллеж байгаа бол гадаадын их сургуулийн салбар сургууль нэг байна.

Зураг 6.2 Дээд боловсролын сургалтын байгууллага, өмчийн хэлбэрээр



*2023 онд БШУ-ны сайдын тушаалаар ХУИС-ийн харьяа Билиг дээд сургууль, Гурван-Эрдэнэ багшийн дээд сургууль, Тэнгэр дээд сургууль, Засагт хан дээд сургууль, Цэцээ гүн дээд сургуулийн тусгай зөвшөөрлийг тус тус хүчингүй болгох шийдвэр гарсан. Мөн Билиг дээд сургуулийг Идэр их сургуульд, Гурван-эрдэнэ, Тэнгэр дээд сургуулийг Санхүү эдийн засгийн их сургуульд, Цэцээ гүн дээд сургуулийг Улаанбаатар-Эрдэм их сургуульд тус тус шилжүүлэн бүртгэх тушаал гарч, оюутан суралцагчдыг шилжүүлэн бүртгэх ажлыг зохион байгуулсан.

Их дээд сургууль, коллежийн **45** буюу **69.2** хувь нь хувийн өмчийн, **17** буюу **26.2** хувь нь төрийн өмчийн, **3** буюу **4.6** хувь нь олон нийтийн/шашны өмчийн сургууль байна. Дээд боловсролын сургалтын байгууллагын **60** буюу **92.3** хувь нь Улаанбаатар хотод, **5** буюу **7.7** хувь нь орон нутагт сургалтын үйл ажиллагаа явуулж байна.

МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА БОЛОН ХӨТӨЛБӨР 2024-2025 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН БАЙДЛААР

Дээд боловсролын сургалтын үйл ажиллагаа явуулж буй нийт **65** их, дээд сургууль, коллежийн **46** буюу **70.8** хувь нь 2024-2025 оны хичээлийн жилд магадлан итгэмжлэл нь идэвхтэй төлөвт байна. 2025 оны 01 дүгээр сарын байдлаар **16** их, дээд сургууль, коллежийн магадлан итгэмжлэлийн үйл ажиллагаа хийгдэж байна. Магадлан итгэмжлэл нь 2024-2025 онд идэвхтэй байгаа нийт **46** сургуулийн **28** буюу **60.9** хувь нь их сургууль, **18** буюу **39.1** хувь нь дээд сургууль байна.

2024-2025 оны хичээлийн жилийн эхэнд:

- **Олон улсын магадлан итгэмжлэлд:** 16 сургуулийн 110 хөтөлбөр, 2023 онд шинээр нэмэгдсэн 1 сургуулийн 3 хөтөлбөр;
- **Дотоодын магадлан итгэмжлэлд:** 44 сургуулийн 389 хөтөлбөр, 2024 онд шинээр нэмэгдсэн 12 сургуулийн 44 хөтөлбөр;
- **Урьдчилсан магадлан итгэмжлэлд:** 39 сургуулийн 209 хөтөлбөр, 2024 онд шинээр 15 сургуулийн 23 хөтөлбөр магадлан итгэмжлэгдсэн байна



6.2 ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГАД СУРАЛЦАГЧИД

Хүснэгт 6.2 Нийт суралцагчид, боловсролын зэрэг, хүйсээр


Үзүүлэлт	2021-2022	2022-2023	2023-2024	2024-2025
Нийт суралцагч	148,954	145,267	145,345	150,282
Үүнээс: Эмэгтэй	91,034	88,823	88,601	92,261
Эрэгтэй	57,920	56,444	56,744	58,021
Диплом	3,155	2,799	2,792	2,620
Үүнээс: Эмэгтэй	2,519	578	2170	2108
Эрэгтэй	636	2,221	622	512
Бакалавр	117,037	112,451	113,322	117,344
Үүнээс: Эмэгтэй	69,803	67,258	67,885	70,797
Эрэгтэй	47,234	45,193	45,437	46,547
Магистр	25,300	25,509	24,171	24,830
Үүнээс: Эмэгтэй	16,717	16,742	15,616	16,199
Эрэгтэй	8,583	8,767	8,555	8,631
Доктор	3,462	4,508	5,060	5,488
Үүнээс: Эмэгтэй	1,995	2,602	2,930	3,157
Эрэгтэй	1,467	1,906	2,130	2,331

Дээд боловсролын сургалтын байгууллагад нийт **150,282** оюутан суралцаж байгаа нь өмнөх оны хичээлийн жилээс **4,937** буюу **3.4** хувиар өссөн байна.

Суралцагчдыг өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад дипломын боловсролд суралцагчид 172-оор буурсан бол, бакалаврын зэрэгт **4,022**, магистрантурт **659**, докторантурт 428-аар суралцагчдын тоо суралцагчдын тоо тус тус өссөн байна.



Зураг 6.3 Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид, боловсролын түвшнээр




Их, дээд сургууль, коллежийн суралцагчдыг боловсролын зэргээр авч үзвэл, нийт суралцагчдын **2620** буюу **1.7** хувь нь диплом, **117,344** буюу **78.1** хувь нь бакалавр, **24,830** буюу **16.5** хувь нь магистр, **5,488** буюу **3.7** хувь нь докторын хөтөлбөрийн сургалтад хамрагдаж байна.

2024-2025 оны хичээлийн жилд суралцагчдын тоо өмнөх оноос өссөн байна.




Зураг 6.4 Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид, хүйсээр



Их, дээд сургууль, коллежид суралцагчдыг хүйсээр авч үзвэл, нийт суралцагчдын **92,261** буюу **61.4** хувь нь эмэгтэй, **58,021** буюу **38,6** хувь нь эрэгтэй байна. Жендерийн тэнцвэрт байдлын индекс буюу **100** эрэгтэй суралцагч тутам ногдох эмэгтэй суралцагчийн тоо **159** буюу өнгөрсөн хичээлийн жилээс уг индекс **0.03** пунктээр нэмэгдсэн байна.

Зураг 6.5 Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын хүйсийн тэнцвэрт байдлын индекс, хувиар




Хүснэгт 6.3 Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид, ангиллаар



	2021/2022	2022/2023	2023/2024	2024-2025
Дээд сургууль	15,688	12,528	11,143	12,303
Коллеж	224	33	37	64
Их сургууль	132,808	132,595	134,165	137,915
Гадаадын их сургуулийн салбар сургууль	234	111	80	88
Нийт суралцагч	148,954	145,267	145,345	150,282

Нийт суралцагчдын 137,915 буюу 91.8 хувь нь их сургуульд, 12,303 буюу 8.2 хувь нь дээд сургуульд, 64 нь коллежид суралцаж байгаа бол 88 оюутан гадаадын их сургуулийн салбар сургуульд суралцаж байна.

Зураг 6.6 Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид, өмчийн хэлбэрээр




Их, дээд сургууль, коллежид суралцагчдыг өмчийн хэлбэрээр авч үзвэл, 2024-2025 оны хичээлийн жилд нийт суралцагчдын **81,571** буюу **54.3** хувь төрийн өмчийн, **60,111** буюу **40.0** хувь нь хувийн өмчийн, **8,600** буюу **5.7** хувь нь олон нийтийн/шашны өмчийн сургуульд суралцаж байна.

Их, дээд сургууль, коллежид суралцагчдын **141,070** буюу **93.9** хувь нь Улаанбаатар хотод, **9,212** буюу **6.1** хувь нь орон нутагт суралцаж байна.

Аймгаар авч үзвэл, 2024-2025 оны хичээлийн жилд хамгийн олон оюутантай нь Дархан-Уул аймаг **4,058** буюу нийт суралцагчдын **2.7** хувийг, хамгийн цөөн суралцагчтай нь Хэнтий аймагт **15** суралцагч байна.



Зураг 6.7 Нийт суралцагчид, сургалтын байгууллагын байршлаар /салбар сургууль/ 2024-2025



Монгол Улсын хүн амын 18-24 насны нийт хүн ам **295,774** байгаагийн **117,347** буюу **39.7** хувь нь бакалаврын боловсролд суралцагчид байна.

Тайлбар: ҮСХ-ны 2023 оны суурин хүн амын тоог нас дэвшүүлэх аргачлалаар тооцсон. Олон улсад бакалаврын зэргийн боловсрол олгох насны бүлгийг 18-24 нас гэж үздэг.

Эх үүсвэр: Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын тодорхойлолтоос, OECD iLibrary (oecd-ilibrary.org)

Хүснэгт 6.4 Нийт суралцагчид, боловсролын түвшин, мэргэжлийн ерөнхий чиглэлээр, 2024-2025

Мэргэжлийн ерөнхий чиглэл	Нийт суралцагчид	Дипломын боловсрол	Бакалаврын боловсрол	Магистрын боловсрол	Докторын боловсрол
Нийт суралцагчид	150,282	2,620	117,344	24,830	5,488
Боловсрол	19,933	-	13,897	4,939	1,097
Урлаг, хүмүүнлэг	11,667	-	9,543	1,077	1,047
Нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүй	10,485	-	8,643	1,384	458
Бизнес, удирдахуй, хууль, эрх зүй	39,561	-	28,110	10,141	1,310
Байгалийн шинжлэх ухаан, математик, статистик	3,775	-	2,727	724	324
Мэдээлэл, харилцааны технологи	7,783	26	7,334	384	39
Инженер, үйлдвэрлэл, барилга угсралт	19,490	182	17,800	1,339	169
Хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй, мал эмнэлэг	2,127	-	1,281	662	184
Эрүүл мэнд, нийгмийн халамж	26,775	2,412	20,642	3,362	359
Үйлчилгээ	7,978	-	6,659	818	501
Ерөнхий суурь хөтөлбөр	708		708	-	-

Зураг 6.8 Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид, хүйс, мэргэжлийн ерөнхий чиглэл, нийт суралцагчдын тоонд эзлэх хувь, 2024-2025




Нийт суралцагчдыг мэргэжлийн ерөнхий чиглэлээр авч үзвэл 2024-2025 оны хичээлийн жилд **39,561** буюу **26.3** хувийг бизнес, удирдахуй, хууль, эрх зүйн мэргэжлийн чиглэлд хамгийн олон суралцагч, нийт суралцагчийн **2,127** буюу **1.4** хувь нь хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй, мал эмнэлгийн салбарын мэргэжлийг хамгийн цөөн тооны суралцагч сонгон суралцаж байна.

Зураг 6.9 Багш мэргэжлээр сургалтын үйл ажиллагаа явуулж буй дээд боловсролын сургалтын байгууллага, өмчийн хэлбэрээр, 2024-2025




Нийт **32** сургууль (төрийн өмчийн-**5**, хувийн өмчийн-**27** сургууль) 2024-2025 оны хичээлийн жилд багш мэргэжлээр сургалтын үйл ажиллагаа явуулж тэдгээрт нийт **13,814** оюутан суралцаж байгаа нь нийт суралцагчдын **9.2** хувийг эзэлж байна.

Зураг 6.10 Дотуур байранд амьдарч буй нийт суралцагч, хүйс, дотуур байрын хангалтын хувь, 2024-2025



Дотуур байранд амьдарч байгаа нийт суралцагчдын **5,009** буюу **96.0** хувь нь бакалаврын боловсролын хөтөлбөрөөр суралцагчид, **40** буюу **0.08** хувь нь дипломын боловсролын хөтөлбөрөөр суралцагчид байна.


Зураг 6.11 Монгол Улсад суралцаж буй нийт гадаад оюутан, улсаар, дүнд эзлэх хувиар, 2024-2025



Монгол Улсын их, дээд сургууль, коллежид нийт **4,722** гадаад оюутан суралцаж байгаагаас хамгийн их буюу **85.8** хувь нь Бүгд Найрамдах Хятад Ард Улсын оюутнууд эзэлж байна.


6.3 ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГАД ЭЛСЭГЧИД

Зураг 6.12 Дээд боловсролын сургалтын байгууллагад элсэгчид, хүйсээр



Элсэгчид 2024-2025 оны хичээлийн жилд **23,703** болж өмнөх оны хичээлийн жилээс **996**-аар өссөн ба шинээр элсэгчдийн **61.7** хувь нь эмэгтэй суралцагч, **38.3** хувийг эрэгтэй суралцагчид эзэлж байна.

Зураг 6.13 Дээд боловсролын сургалтын байгууллагад элсэгчид, тухайн жилд бүрэн дунд боловсрол эзэмшигчдээс элссэн байдал



Элсэгчдийн дотор тухайн жилд бүрэн дунд боловсрол эзэмшигчдийн эзлэх хувь 2024-2025 оны хичээлийн жилд **77.2** хувь болж, өмнөх жилээс **0.9** пунктээр өссөн байна.

Тухайн жилд буюу 2024 онд бүрэн дунд боловсрол эзэмшигчид **35,506** байгаагийн **51.5** хувь нь дээд боловсролын сургалтын байгууллагад элсэн суралцаж байна.



Хүснэгт 6.5 Дээд боловсролын сургалтын байгууллагад элсэгчид, 2024-2025 он


	Элсэгчид	Эзлэх хувь
Тухайн жилд бүрэн дунд боловсрол эзэмшигчдээс	18,298	77.2
Тухайн жилд техникийн болон мэргэжлийн боловсрол эзэмшигчдээс	132	0.6
Тухайн жилд бакалаврын боловсрол эзэмшигчдээс	4,658	19.7
Бусад	615	2.5

2024-2025 оны хичээлийн жилд элсэгчдийн **18,298** буюу **77.2** хувь нь тухайн жилд бүрэн дунд боловсрол эзэмшигчдээс, **4,658** буюу **19.7** хувь нь тухайн жилд бакалаврын боловсрол эзэмшигчдээс, **132** буюу **0.6** хувь нь тухайн жилд мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшигчдээс тус тус элссэн байна.



6.4 ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫГ ТӨГСӨГЧИД

Зураг 6.14 Дээд боловсролын сургалтын байгууллагыг төгсөгчид, хүйсээр



Их, дээд сургуулийг 2023-2024 оны хичээлийн жилд **27,555** суралцагч төгсөж өмнөх оны хичээлийн жилээс **4,241** буюу **18.2** хувиар өссөн бөгөөд нийт төгсөгчдийн **17,457** буюу **63.4** хувь нь эмэгтэй, **10,098** буюу **36.6** хувь нь эрэгтэй төгсөгчид байна.

Хүснэгт 6.6 Дээд боловсролын сургалтын байгууллагыг төгсөгчид, боловсролын зэргээр

	2021/2022	2022/2023	2023/2024
Нийт төгсөгч	32,925	23,314	27,555
Диплом	627	1,102	1,087
Бакалавр	26,240	17,260	20,906
Магистр	5,954	4,860	5,421
Доктор	104	92	141


Нийт төгсөгчдийг боловсролын зэргээр авч үзвэл, 2023-2024 оны хичээлийн жилд **20,906** буюу **75.9** хувь нь бакалавр, **5,421** буюу **19.7** хувь нь магистр, **1,087** буюу **3.9** хувь нь диплом, **141** буюу **0.5** хувь нь докторын зэрэг эзэмшсэн байна.

Ажиллах хүчний судалгааны 2024 оны III улирлын байдлаар ажилгүй иргэдийн тоо 88.1 мянган хүн байгааг насны бүлгээр авч үзвэл 21.2 мянга (24.1 хувь) нь 15-24 насны, 24.8 мянга (28.1 хувь) нь 25-34 насны, 22.0 мянга (25.0 хувь) нь 35-44 насны, 13.4 мянга (15.2 хувь) нь 45-54 насны, 6.7 мянга (7.6 хувь) нь 55, түүнээс дээш насны хүн байна. Өмнөх оны мөн үеэс 15-24 насны ажилгүй иргэдийн тоо 5.4 мянгаар нэмэгдсэн байна.

Гэр бүл, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яамны 2024 оны IV улирлын захиргааны статистикийн мэдээллээс Хөдөлмөр, халамжийн байгууллагад ирж бүртгүүлж байгаа бүртгэлтэй ажилгүй иргэнийг боловсролын түвшнээр нь харахад, ажилгүйчүүдийг боловсролын түвшнээр ангилбал 1.7 хувь нь магистр болон түүнээс дээш, 26.4 хувь нь Дипломын болон бакалаврын дээд, 4.9 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 9.1 хувь нь техникийн болон мэргэжлийн, 44.1 хувь нь бүрэн дунд, 8.7 хувь нь суурь, 3.8 хувь нь бага, 1.2 хувь нь боловсролгүй иргэд байна. Ажилгүй 3 хүн тутмын 1 нь бүрэн дунд боловсролтой байна.

Эх үүсвэр: УСХ, 1212 статистикийн мэдээллийн нэгдсэн сангаас

Зураг 6.15 Дээд боловсролын сургалтын байгууллагыг төгсөгчид, мэргэжлийн чиглэлээр, 2023/2024



Дээд боловсролын сургалтын байгууллагыг 2023-2024 оны хичээлийн жилд нийт төгсөгчдийн хамгийн их нь буюу **8,816** буюу **32.0** хувь нь бизнес, удирдлага, эрх зүйн салбарын мэргэжлүүдээр, хамгийн бага нь буюу **270** буюу **1.0** хувь нь хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй, мал эмнэлзүй салбарын мэргэжлүүдээр төгссөн байна.

Инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээлт, Мэдээлэл, харилцаа холбооны технологи, үйлчилгээний салбарын мэргэжлүүдээр эрэгтэйчүүд илүү төгссөн бол Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, боловсрол, нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүлзүй, урлаг, хүмүүнлэг, соёл урлаг болон бусад мэргэжлээр эмэгтэйчүүд илүү төгссөн байна.

Зураг 6.16 Дээд боловсролын сургалтын байгууллагыг төгсөгчид, хүйс, мэргэжлийн чиглэлээр, хувиар, 2023/2024



Хүснэгт 6.7 Боловсролын зээлийн сангийн тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламжид хамрагдан гадаадад суралцагч, 2024-2025 оны хичээлийн жил

Суралцагчийн тоо		1,061		
		Эмэгтэй	649	
		Эрэгтэй	412	
		Мөнгөн дүн (мян.төг)	36,915,480	
Санхүүгийн дэмжлэгийн төрөл	Гадаад зээл - Өндөр хөгжилтэй орон (Магистр)	Суралцагчийн тоо	7	
			Эмэгтэй	4
			Эрэгтэй	3
		Мөнгөн дүн (мян.төг)		690,831
	Гадаад зээл - Дэлхийн шилдэг (Бакалавр)	Суралцагчийн тоо		186
			Эмэгтэй	124
			Эрэгтэй	62
		Мөнгөн дүн (мян.төг)		8,970,075
	Засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээр	Суралцагчийн тоо		65
			Эмэгтэй	44
			Эрэгтэй	21
		Мөнгөн дүн (мян.төг)		518,160
	Ерөнхий сайдын нэрэмжит сургалтын тэтгэлэг	Суралцагчийн тоо		45
			Эмэгтэй	31
			Эрэгтэй	14
		Мөнгөн дүн (мян.төг)		2,357,716
	Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлэг	Суралцагчийн тоо		758
			Эмэгтэй	446
		Эрэгтэй	312	
		Мөнгөн дүн (мян.төг)	21,832,251	
Зориулалтын төрөл	Сургалтын төлбөр	Суралцагчийн тоо	549	
		Мөнгөн дүн (мян.төг)	22,888,828	
	Амьжиргааны зардал	Суралцагчийн тоо	553	
		Мөнгөн дүн (мян.төг)	3,605,039	
	Бусад (Дотуур байр)	Суралцагчийн тоо	310	
	Мөнгөн дүн (мян.төг)	7,875,167		

Эх үүсвэр: Боловсролын зээлийн сангийн 2023-2024 оны хичээлийн жилийн статистикийн мэдээ

6.5 ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН БАГШ, АЖИЛЛАГЧИД

Хүснэгт 6.8 Дээд боловсролын сургалтын байгууллагын нийт үндсэн багш, ажиллагчид, хүйсээр


	2021-2022	2022-2023	2023-2024	2024-2025
Нийт ажиллагчид	12,175	11,923	11,664	11,403
Үүнээс: Эмэгтэй	7,688	7,573	7,457	7345
Эрэгтэй	4,487	4,350	4,207	4058
Үндсэн багш	6,102	5,169	5,112	5,151
Үүнээс: Эмэгтэй	3,740	3,169	3,141	2,008
Эрэгтэй	2,362	2,000	1,971	3,143
Нийт ажиллагчдын дүнд үндсэн багшийн эзлэх хувь	50.1	43.3	43.8	45.2

6. ДЭЭД БОЛОВСРОЛ



Их, дээд сургууль, коллежийн ажиллагчид 2024-2025 оны хичээлийн жилд **11,403** болж өмнөх оны хичээлийн жилээс **261** буюу **2.2** хувиар буурсан байна. 2024-2025 оны хичээлийн жилд дээд боловсролын сургалтын байгууллагын нийт ажилтны **7,345** буюу **64.4** хувь нь эмэгтэй, **4,058** буюу **35.6** хувь нь эрэгтэй байна.


Зураг 6.17 Дээд боловсролын сургалтын байгууллагын үндсэн багш, ажиллагчид, өмчийн хэлбэрээр, 2024-2025



Өмчийн хэлбэрээр авч үзвэл, 2024-2025 оны хичээлийн жилд ажиллаж байгаа нийт ажиллагчдын **7,019** буюу **61.6** хувь нь төрийн өмчийн сургуульд, **3,991** буюу **35.0** хувь нь хувийн өмчийн сургуульд, **393** буюу **3.1** хувь нь олон нийтийн/шашны өмчийн сургуульд ажиллаж байна.


Өмчийн хэлбэрээр авч үзвэл харахад, 2024-2025 оны хичээлийн жилд ажиллаж байгаа нийт үндсэн багшийн **3,322** буюу **65.0** хувь нь төрийн өмчийн сургуульд, **1,647** буюу **32.2** хувь нь хувийн өмчийн сургуульд, **143** буюу **2.8** хувь нь олон нийтийн/шашны өмчийн сургуульд ажиллаж байна.

Зураг 6.18 Дээд боловсролын сургалтын байгууллагын үндсэн багш, боловсролын түвшнээр, 2024-2025



Их, дээд сургууль, коллежид ажиллаж буй үндсэн багшийн **2,494** буюу **48.4** хувь нь магистр, **2,325** буюу **44.1** хувь нь доктор, **327** буюу **6.3** хувь нь бакалавр, **5** буюу **0.1** хувь нь дипломын боловсролтой байна.

Зураг 6.19 Дээд боловсролын сургалтын байгууллагын нийт үндсэн багш, нас хүйсийн суварга, дүнд эзлэх хувь



Нийт **5,151** үндсэн багш ажиллаж байгаагийн **3,143** буюу **61.0** хувь нь эмэгтэй, **2,008** буюу **39.0** хувь нь эрэгтэй байна. Насны хувьд үндсэн багшийн **358** буюу **7.0** хувь нь 30 хүртэлх насны, **1,454** буюу **28.2** хувь нь 30-40 насны, **1,747** буюу **33.9** хувь нь 40-50 насны, **1062** буюу **20.6** хувь нь 50-60 насны, **530** буюу **10.3** хувь нь 60 ба түүнээс дээш насны багш нар тус тус эзэлж байна.

Улсад ажилласан жилээр нь үндсэн багш нарыг ангилж үзэхэд **21.5** хувь нь 1-5 жил, **15.1** хувь нь **6-10** жил, **19.8** хувь нь **11-15** жил, **11.7** хувь нь **16-20** жил, **9.6** хувь нь **21** болон түүнээс дээш жил ажиллаж байгаа үндсэн багш нар байна.

Их, дээд сургууль, коллежид ажиллаж буй үндсэн багш 2024-2025 оны хичээлийн жилд **5,151** болж өмнөх хичээлийн жилээс **39** буюу **0.7** хувиар буурсан байна. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны тушаалаар хувийн өмчийн **4** их, дээд сургууль, коллежийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, бусад сургуультай нэгтгэн зохион байгуулсантай холбоотойгоор үндсэн багшийн тоо буурсан байна.






07

НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛ

7.1

БОЛОВСРОЛ НӨХӨН ОЛГОХ ХӨТӨЛБӨРӨӨР*
СУРАЛЦАГЧ, ТӨГСӨГЧИД

Зураг 7.1 Боловсрол нөхөн олгох хөтөлбөрөөр суралцагчдын тоо



Зураг 7.2 Боловсрол нөхөн олгох хөтөлбөрөөр төгсөгчид, 2023/2024



Хүснэгт 7.1 Боловсрол нөхөн олгох хөтөлбөрөөр төгсөгчид, аймаг, боловсролын түвшнээр, 2023/2024

Аймаг	Боловсрол нөхөн олгох сургалтын төгсөгчид	Бага боловсрол	Суурь боловсрол	Бүрэн дунд боловсрол
Архангай	100	0	24	76
Баян-Өлгий	92	3	35	54
Баянхонгор	177	8	67	102
Булган	43	14	14	15
Говь-Алтай	86	6	23	57
Дорноговь	2	1	0	1
Дорнод	21	0	10	11
Дундговь	20	2	12	6
Завхан	79	2	31	46
Өвөрхангай	113	10	42	61
Өмнөговь	7	1	6	0
Сүхбаатар	42	11	31	0
Сэлэнгэ	82	11	47	24
Төв	80	5	20	55
Увс	191	21	92	78
Ховд	234	8	76	150
Хөвсгөл	134	4	45	85
Хэнтий	15	1	6	8
Дархан-Уул	43	6	20	17
Улаанбаатар	434	55	168	211
Орхон	60	3	19	38
Говьсүмбэр	29	0	10	19

Тайлбар: **Сургуульд элсэх хуулийн насандаа сургуульд ороогүй эсвэл сургуульд сурч байгаад завсардсан хүүхдэд бага, суурь, бүрэн дунд боловсролыг нөхөн эзэмшүүлэх* хөтөлбөр юм.

